

Төсөл

## ДЭЛХИЙН САЙН ДУРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТАНДАРТ

2021 оны 10 сар

Орчуулгыг хянан тохиолдуулсан:

**Г.УНДРАЛ**

Сайн дурынхны байгууллагуудын сүлжээний тэргүүн

[undral.gombodori@gmail.com](mailto:undral.gombodori@gmail.com)

+976 99164419

[www.volunteers.mn](http://www.volunteers.mn)

2024 оны 5-р сарын 31

Улаанбаатар

Монгол Улс

## Танилцуулга

Дэлхий даяар олон нийтийг дэмжиж, өөрчлөлтийг бий болгохын тулд өөрсдийн цагийг сайн дураараа зориулдаг олон хүмүүсийн ашиг тусыг нийгэм хүртдэг. Сайн дурынхан бол хөгжлийн хамтын ажиллагааны онцгой бөгөөд хүчирхэг ажиллах хүч юм. Ялангуяа тэднийг сайн бэлтгэж, дэмжиж, үйлчилж буй орон нутгийн иргэдтэй эрх тэгш хамтран ажиллаж, тодорхойлж, боловсруулсан төслүүдэд хувь нэмрээ оруулж буй тохиолдолд.

Хөгжлийн төлөөх сайн дурын олон улсын Форум (цаашид Форум гэх) хөгжлийн төлөө сайн дурын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудын хамгийн чухал дэлхийн сүлжээ юм. Тус Форумын үйл ажиллагаа мэдээлэл солилцох, сайн туршлагыг хөгжүүлэх, хөгжлийн төлөөх сайн дурын салбарын хамтын ажиллагааг сайжруулахад оршино.

2016 онд Форум нь сайн дурынхны оролцоотой байгууллагуудад дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн анхны стандартыг бий болгохоор зорьсон. Дэлхийн сайн дурын үйл ажиллагааны стандартыг бий болгох Форумын гол зорилго нь илүү үр дүнтэй, илүү хариуцлагатай сайн дурын үйл ажиллагааг сурталчлах, дэмжихэд оршиж байв. Үүнд хүрэхийн тулд сайн дурынхны оролцоотой байгууллагууд ажлаа сайн төлөвлөх, ил тод, хүндэтгэлтэй, хамтын түншлэл, хэмжигдэхүйц үр дүнд тулгуурласан байх ёстой. Хэрэв бид үүнд хүрч чадвал Тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх, хүмүүсийн амьдралыг сайжруулахад сайн дурынхан хамгийн их хувь нэмэр оруулна.

Дэлхийн стандарт нь гурван жилийн турш хийсэн дэлхийн нийтийн хамтын хүчин чармайлтын үр дүн юм. Энэхүү төсөлд хөгжлийн болон бусад салбарт сайн дурын ажил эрхэлдэг дэлхийн 80 гаруй орны хэдэн зуун хүн, байгууллагын туршлага, мэргэн ухааныг ашигласан. Тэд Дэлхийн стандартыг боловсруулахын тулд судалгаа, санал асуулга, семинар, лавлах бүлгүүдэд оролцсон. 2020 онд дэлхийн 18 байгууллага Өөрийгөө үнэлэх үйл явцаар дамжуулан Дэлхийн стандартыг туршсан ба тэдний туршлагын тойм дээр үндэслэн таны одоо уншиж буй Дэлхийн стандартыг бий болгосон. Форум нь Дэлхийн стандартыг боловсруулах, турших, хянах үйл явцад өргөн хүрээний оролцогч талуудыг идэвхтэй оролцуулж, сайн дурын салбарынхан сайн дурын салбарт зориулж боловсруулсан нөөцийг бий болгосон. Энэ төсөлд хувь нэмрээ оруулсан бүх хүмүүст болон Форумын стандартын ажлын хэсгийн хамт олон манлайлан ажилласанд бид гүнээ талархаж байна.

Дэлхийн стандарт нь сайн дурын хөтөлбөрийн хүрээнд - төсөл боловсруулах, хэрэгжүүлэхээс эхлээд Халамжийн Зорилт, Сайн дурынхны удирдлага, Нөлөөллийг хэмжих хүртэлх туршлагын талаар бидний хамтын ойлголтыг оруулж тусгасан.

Сайн дурынхантай хамтран ажилладаг байгууллагуудад Дэлхийн стандарт нь суралцах, сайжруулах аяллын эхний алхам юм. Та үүнийг уншиж, хамт олонтойгоо ярилцаж, танай байгууллагад ямар хамааралтай болохыг бодож үзнэ гэдэгт бид итгэж байна. Энэ стандарт сайн дурын үйл ажиллагааны үр нөлөөг бэхжүүлж, нэмэгдүүлэхэд тусална гэдэгт бид итгэж байна.

Байгууллагуудад Дэлхийн стандартыг ашиглаж, туршлагыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Форум нь Сайн дурын үйл ажиллагааны стандарт, Байгууллагын

өөрийгөө үнэлэх хэрэгсэл болон хөгжлийн төлөөх сайн дурын тэргүүлэгч байгууллагуудаас хуримтлуулсан сайн түршлагын Номын сан гэдгээс бүртсэн гурван хэсэг бүхий цахим талбар/платформыг хөгжүүлж бий болгосон. Илүү ихийг мэдэхийг хүсвэл [forum-ids.org/standard](http://forum-ids.org/standard) руу орж танилцана уу.

Дэлхийн сайн дурын үйл ажиллагааны стандартаар дамжуулан Форум нь сайн дурын үйл ажиллагааг илүү хариуцлагатай болон илүү үр нөлөөтэй болгохын төлөө ажиллаж буй сайн дурынхны оролцоотой бүх байгууллагуудтай хамтран ажиллахад бэлэн байна.

**Марк Камминг, Стивен Гудман нар**

Хамтран Удирдагчид, Форумын стандартын Ажлын хэсэг  
Форумын Удирдах зөвлөлийн гишүүд

## 2021 оны Дэлхийн сайн дурын үйл ажиллагааны стандартын шинэчлэл

Дэлхийн сайн дурын үйл ажиллагааны стандартын нээлт 2019 онд Форумын жил бүр болдог IVCO бага хурал дээр болсон. 2020 онд Дэлхийн стандартыг туршиж үзсэний дараа Форум нь энэ стандартыг хөгжлийн төлөөх нийгэмлэгийн сайн дурын үйл ажиллагаанд өргөнөөр нэвтрүүлэхээс өмнө хянаж, шинэчилсэн. Эдгээр шинэчлэлийг доор онцолсон 5 Үндсэн чиглэлд хандуулсан.

**Цахим сайн дурын үйл ажиллагаа:** Цахим сайн дурын үйл ажиллагаа нэмэгдэж байгаатай холбогдуулан, ялангуяа КОВИД-19 цар тахлын улмаас, Форум нь Дэлхийн стандартын агуулгыг цахим сайн дурын үйл ажиллагаанд хэрхэн тохируулах талаар судлахаар шийдсэн. Дэлхийн стандартын агуулгыг цахим болон алсын зайны сайн дурын үйл ажиллагааны хөтөлбөрөөр дамжуулан хянасан. Энэхүү хяналтаар дамжуулан Форум нь Дэлхийн стандарт цахим сайн дурын үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой болохыг тогтоосон ч цаашид цахим болон алсын зайны сайн дурын үйл ажиллагаанд хамрагдахад нэмэлт сайжруулалт шаардлагатай байв.

**Халамжийн Зорилт:** Энэ бол байнга ахиж дэвшиж байдаг салбар тул Стандартад шилдэг туршлагыг тусгаж байгаа эсэхийг тасралтгүй баталгаажуулах шаардлагатай. Бүх Үндсэн үйл ажиллагаа, үзүүлэлтүүдийг хянасан ба шаардлагатай гэж үзсэн зүйлсийг шинэчилсэн. Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөг, дарамт шахалт, жендерт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авахтай холбоотой нэмэлт агуулгыг нэмсэн

**Байгаль орчныг хамгаалах:** IVCO 2020 нь хөгжлийн төлөөх үйл ажиллагаанд сайн дурын үйл ажиллагаа явуулах нь Уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх хөтөлбөрийг дэмжихийн ач холбогдол, хамаарлыг онцолсон. Хөгжлийн төлөөх үйл ажиллагаанд сайн дурын үйл ажиллагаа явуулах нь байгаль орчинд хор хөнөөл учруулахгүй байх нэмэлт агуулгыг нэмсэн.

**Сайн дурын олон талт байдал ба олон нийтийн оролцоо:** Дэлхийн стандартыг боловсруулах явцад бид сайн дурынхны олон талт байдал, олон нийтийн оролцоог дэмжих нь анхаарлын гол цөм гэдгийг хүлээн зөвшөөрсөн. Анхны Дэлхийн стандарт эдгээр ойлголтыг багтаасан боловч Форум үүн дээр тулгуурлан сайн дурын үйл ажиллагааны боломжийг илүү өргөн хүрээний сайн дурынханд хүртээмжтэй байлгах, хөгжлийн төлөөх үйл ажиллагаанд сайн дурын үйл ажиллагааны үр нөлөөг үнэлэх, шийдвэр гаргахад олон нийтийг хамруулах зорилгоор Дэлхийн стандартын одоогийн агуулгад нэмэлт өөрчлөлтийг оруулсан.

**Агуулгын хүртээмжтэй байдал:** 2020 онд Дэлхийн стандартыг туршиж үзсэн байгууллагууд сайн дурынхны оролцоотой бүх байгууллагуудад зарим нэр томьёо ойлгомжгүй байна гэж үзсэн. Дэлхийн стандартыг олон хэлээр орчуулах тул нэр томьёог аль болох нийтлэг байлгаж, Дэлхийн стандартын хэлийг энгийн бөгөөд ойлгомжтой англи хэл дээр байлгах үүднээс одоогийн стандартыг шинэчилсэн.

## Дэлхийн сайн дурын үйл ажиллагааны стандартын гол тулгуур

**Дэлхийн сайн дурын үйл ажиллагааны стандарт** бол хөгжлийн болон бусад салбарын олон зуун оролцогч талууд, дэлхийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн туршлагын иж бүрэн багцаас суралцах, сайжруулах, нийцүүлэх зорилгоор сайн дурынхны оролцоотой байгууллагууд бүрэн эсвэл хэсэгчлэн хэрэгжүүлэхээр сонгож болох практик стандарт юм. Дэлхийн стандарт нь хөгжлийн төлөөх үйл ажиллагаанд сайн дурын үйл ажиллагааны үр дүнг сайжруулах зорилгоор сайн дурынхнаар дамжуулан үйл ажиллагаа эрхэлдэг болон хамтран ажилладаг байгууллагуудыг хариуцлагатай, бодит үр дүнтэй байлгах сайн дурын стандарт юм.

**Дараах тодорхойлолтууд Дэлхийн стандартын гол тулгуурыг бүртүүлж байна. Үүнд:**

**Хөгжлийн төлөөх сайн дурын үйл ажиллагаа** нь Тогтвортой хөгжлийн зорилтын дагуу ядуурал, тэгш бус байдлыг арилгахад туслахын тулд хүмүүс, олон нийттэй мөр зэрэгцэн ажиллаж, тэдний амьдралын чанарыг сайжруулж, өөрсдийн чадавхийг дэмжих сайн дурынхны үр чадварт тулгуурладаг. Хөгжлийн төлөөх үйл ажиллагаанд сайн дурын үйл ажиллагаа явуулахдаа үргэлж үр дүнтэй, хариуцлагатай байхыг зорих ёстой.

**Хариуцлагатай сайн дурын үйл ажиллагаа** нь сайн дурын үйл ажиллагааг орон нутгийн хэмжээнд тодорхойлж, тэдгээр бүлгүүдийн тодорхойлсон хэрэгцээг хангахад чиглэсэн байхыг баталгаажуулдаг. Сайн дурынхныг сонгон шалгаруулж бэлтгэснээр тэднийг нийгмийн бүлэгтэй эрх тэгш хамтран ажиллаж, үр нөлөөтэй сайн дурын үйл ажиллагаа явуулах боломжтойг баталгаажуулдаг. Эдгээр үйл ажиллагааг явуулахад нийгмийн бүлгийн гишүүд болон сайн дурынханд ямар ч хор хөнөөл учрах ёсгүй.

**Үр нөлөөтэй сайн дурын үйл ажиллагаа** нь улс орны үндэсний хөгжлийн хөтөлбөр, Тогтвортой хөгжлийн зорилттой нийцсэн ядуу, гадуурхагдсан нийгмийн бүлэгт хэмжигдэхүйц, тогтвортой сайжруулалтыг бий болгодог.

## Дэлхийн сайн дурын үйл ажиллагааны стандартын БҮТЭЦ

Дэлхийн стандарт нь хэлэлцүүлгийн үеэр Форумгаас тэргүүлэх ач холбогдол өгсөн харилцан уялдаатай дөрвөн **СЭДЭВТ** хуваагддаг. Эдгээр нь:

1. Төсөл боловсруулах, хэрэгжүүлэх
2. Халамжийн Зорилт
3. Сайн дурынхныг удирдах
4. Үр нөлөөг хэмжих

**СЭДЭВ** бүр нь бүтцийн хэсгүүдийн ижил шатлалыг агуулдаг - **Зорилт, Хамрах хүрээ, Чиглэл, Тайлбар, Гол арга хэмжээ, Үзүүлэлтүүд**. Эдгээр хэсэг бүр бусдаасаа хамааралтай байдаг.

**Зорилт** - Сэдэв тус бүрийн суурь болсон байгууллагын чухал үүрэг хариуцлагыг онцолсон мэдэгдлүүд.

**Хамрах хүрээ** - Сэдэв тус бүрийн агуулга нь хэнд хамаатай болон хэрэгжилтээс хүсэн хүлээж буй үр дүнгийн тойм.

**Чиглэл** - Сэдэв тус бүрийн үндэс суурийг бүртүүлэх нийлмэл тодорхой хэсгүүд.

**Тайлбар** - Чиглэл бүр юуг хамарч байгааг тодруулна.

**Гол арга хэмжээ** – Байгууллагууд өөрсдийн үйл ажиллагааг Тайлбарт тусгасан зүйлтэй нийцүүлэх арга хэмжээнүүд.

*Эдгээрийг хамгийн наад захын стандарт болох Үндсэн гол арга хэмжээ болон сайн туршлагын стандарт болох Цогц гол арга хэмжээ гэж ангилна.*

**Үзүүлэлтүүд** - Гол арга хэмжээг амжилттай хэрэгжүүлэхийг нотлох шалгуур.

## **Дэлхийн сайн дурын үйл ажиллагааны стандартад хамрагдах нь**

Дэлхийн сайн дурын үйл ажиллагааны стандарт нь сайн дурынхны оролцоотой байгууллагууд өөрсдийн үйл ажиллагааг илүү хариуцлагатай, үр нөлөөтэй ахиулахад хамгийн тохиромжтой хэлбэрээр ашиглаж болох хэрэгсэл юм. Байгууллагуудыг Дэлхийн стандартад хамрагдаж болох арга зам болон хандах боломжтой нөөц, дэмжлэгийг доор харуулав.

### **Дэлхийн сайн дурын үйл ажиллагааны стандартын Дэмжигч болох**

Сайн дурынхны оролцоотой байгууллага эсвэл эвсэл, сүлжээ нь Дэлхийн стандартыг дэмжих, баримтлах тухайгаа илэрхийлж болно. Дэлхийн стандартыг дэмжигч нь Дэлхийн стандартын Үндсэн тулгуур багана болон дөрвөн зорилтын тунхагт тусгагдсан хариуцлагатай, үр нөлөөтэй үйл ажиллагааг өрнүүлэхийг дэмжиж ажиллахаа илэрхийлж байна гэсэн үг. Байгууллага нь Дэлхийн стандартын зарчмыг дэмжиж буйг албан ёсоор бүртгүүлэхийн тулд Форумтай [globalvolunteeringstandard@forum-ids.org](mailto:globalvolunteeringstandard@forum-ids.org) цахим шуудангаар холбогдоно.

### **Дэлхийн сайн дурын стандартын дадлагажигч болох**

Сайн дурынхны оролцоотой байгууллага нь Дэлхийн стандартын дадлагажигч болох боломжтой. Үүнийг Дэлхийн стандартыг татаж авч танилцах, Өөрийн үнэлгээний хэрэгслийг бөглөх эсвэл Нөөцийн номын санд хандах замаар хийж болно. Өөрийн үнэлгээний дараа байгууллагууд үйл ажиллагаагаа сайжруулах, суралцах арга хэмжээг тусгасан төлөвлөгөө боловсруулан ажиллаж болно. Эхлэхийн тулд [www.forum-ids.org/global-volunteering-standard-platform/](http://www.forum-ids.org/global-volunteering-standard-platform/) -оор зочилно уу.

### **Нөөц ба дэмжлэг**

Хэрэв Форумын сайн дурынхны оролцоотой байгууллагуудын сүлжээтэй өөрийн сайн туршлагын эх сурвалжаа хуваалцах, эсвэл Дэлхийн стандартыг хэрэгжүүлэхэд дэмжлэг авахыг хүсвэл: [globalvolunteeringstandard@forum-ids.org](mailto:globalvolunteeringstandard@forum-ids.org) имэйл хаягаар холбогдоно уу.

# ДЭЛХИЙН САЙН ДУРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТАНДАРТ

## ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ

**Зорилт:** Олон нийт, байгууллага, сайн дурынхан олон нийтийн хэрэгцээнд нийцсэн, үр нөлөө, тогтвортой үр дүнд хүргэх хамтран боловсруулсан, үр дүнтэй хэрэгжүүлэх хөгжлийн төлөөх сайн дурын төслүүдэд оролцох боломжтой.

**Хамрах хүрээ:** Үүнийг хөгжлийн төлөөх сайн дурын үйл ажиллагааг боловсруулах, хэрэгжүүлэх зорилго бүхий аливаа байгууллага эсвэл түнш баримтлах ёстой. Төслийн хугацааны туршид эдгээр үйл ажиллагааг үр нөлөөтэй, хариуцлагатай боловсруулах, хэрэгжүүлэх орчныг бүртүүлнэ.

### ЧИГЛЭЛ 1: БОЛОВСРУУЛАЛТ БА ТӨЛӨВЛӨГӨӨ

**Тайлбар:** Хариуцлагатай, үр нөлөөтэй аөгжлийн төлөөх сайн дурын үйл ажиллагааны төслийг боловсруулах, төлөвлөх нь уг төслийг илүү өргөн хүрээний хөгжлийн зорилтод нийцүүлж, орон нутгийн гишүүд удирдах бөгөөд "ямар ч хор хөнөөл учруулахгүй" байх ёстой.

	Гол арга хэмжээ	Үзүүлэлтүүд
1.1	Чадавхи бэхжүүлж, орон нутгийн оролцоог хангахын тулд түншүүдийн хооронд бат бэх харилцааг үүсгэнэ.	<p>1.1а Түншүүдийн чадавх, үр чадвар төслийн болон хандивлагчийн шаардлагад нийцэж байгаа эсэхийг зохих шалгалтын тусламжтайгаар үнэлнэ.</p> <p>1.1б Түншүүд, хандивлагчид бие биеийнхээ оруулах хувь нэмэр, хүлээлт, үүрэг хариуцлагыг тодорхойлсон гэрээг харилцан боловсруулж гарын үсэг зурна - орон нутгийн болон шаардлагатай бол олон улсын хэмжээнд.</p> <p>1.1в Түншүүд, хандивлагчид энэхүү гэрээг харилцан тохиролцсон түншлэлийн хугацаанд хамтдаа хянаж, баримтжуулан найдвартай хадгална.</p> <p>1.1г Түншүүд, хандивлагчид төслийн хугацааны туршид хамтын ажиллагааг хангахын тулд харилцааны найдвартай механизмыг байгуулна.</p>
1.2 Үндсэн	Төслийн боловсруулалт нь эрх дээр суурилсан, хүртээмжтэй хандлагыг ашиглан судалгаа, байгууллагын сургалт, олон нийтийн ашиг сонирхол,	<p>1.2а Байгууллагууд олон нийтийн гишүүдийн хэрэгцээ, эрхийг тодорхойлсон төслийг боловсруулж, үр дүнгийн хүртээмжтэй, тогтвортой байдлыг хангана.</p> <p>1.2б Байгууллагууд, олон нийт хамтран олон нийтээр удирдуулсан нөхцөл байдлын нарийвчилсан үнэлгээ хийнэ.</p> <p>1.2в Олон нийт төслийн тодорхой стратегийн зорилгыг тодорхойлоход тусална.</p> <p>1.2г Олон нийт оролцох бүх иргэдийн эрхийг хүндэтгэж байгаа эсэхийг шалгаж, төслийг эхлүүлэхээс өмнө баталгаажуулна.</p>

	хэрэгцээнд тулгуурлана.	<p>1.2д Байгууллагууд бүх хөтөлбөрийг хүүхэд, эмзэг бүлгийн насанд хүрэгчид болон олон нийтийг хамгаалах шилдэг туршлагад нийцүүлэн боловсруулна. Энэ нь бусад зарчмуудаас гадна асрамжийн газарт сайн дурын үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрөхгүй гэсэн үг.</p> <p>1.2е Төслийг боловсруулах алхам бүрт хамрах хүрээ, амжилт ямар байхыг тодорхойлон олон нийт оролцоно.</p>
1.3	Төслийн хэрэгцээнд нийцсэн сайн дурын ажилтны үүргийг боловсруулах ба орон нутгийн иргэдийн ажлыг авахгүй байх.	<p>1.3а Байгууллагууд сайн дурынхан, олон нийтийн гишүүдэд ашиг тусаа өгөх сайн дурын ажилтны үүргийг боловсруулна.</p> <p>1.3б Байгууллагууд сайн дурын ажилтны үүргийг боловсруулахдаа “хор хөнөөл учруулахгүй” гэсэн зарчмыг баримтална. Төсөл нь заримдаа олон нийтийг хүсээгүй сөрөг үр дагаварт хүргэж болзошгүйг хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд үүнийг тодорхойлж, багасгах шаардлагатай.</p> <p>1.3в Байгууллагууд тухайн улсад ямар мэргэжлийн үр чадвар байдгийг ойлгохын тулд хөдөлмөрийн зах зээлийн судалгаа хийнэ.</p> <p>1.3г Байгууллагууд сайн дурын Зорилт нь олон нийтийн хүсэл эрмэлзэлд нийцүүлэн дасан зохицож чадна гэдгийг баталгаажуулна.</p> <p>1.3д Бүх түншүүд, хандивлагчид сайн дурын үр чадвар, туршлага нь төслийн зорилго, үйл ажиллагаатай үнэн зөв нийцэж, бүх Зорилт хариуцлагыг бүрэн үнэлж байгаа эсэхийг баталгаажуулахын тулд шаардлагатай нөөцийн тал дээр санал нэгдэх ёстой.</p>
1.4 Үндсэн	Төсөл нь урт хугацааны тогтвортой хөгжлийн үр нөлөөг бий болгохыг баталгаажуулна.	<p>1.4а Олон нийт, түншүүд төслийн гол зорилго нь орон нутгийн чадавхийг дээшлүүлэхэд чиглэсэн эсэхийг баталгаажуулна.</p> <p>1.4б Олон нийт, байгууллагууд төслийг олон нийтийн тогтвортой хөгжлийн зорилтыг илүү өргөн хүрээнд ахиулж, боломжтой бол илүү өргөн, урт хугацааны хөгжлийн хөтөлбөрт хувь нэмэр оруулах хэрэгтэй.</p> <p>1.4в Байгууллагууд олон нийтэд зориулсан үр өгөөжийг хангахад төслийн үнэ цэнийг харуулсан нотлох баримтыг үзүүлнэ.</p> <p>1.4г Олон нийт, байгууллагууд сайн дурынхан аливаа Үндсэн болон Үндсэн үйлчилгээ үзүүлэх Зорилт гүйцэтгэж байгаа газартаа хувь нэмрээ оруулах тогтвортой байдлын тодорхой төлөвлөгөөтэй байна.</p>
1.5 Үндсэн	Байгаль хамгаалах, байгаль орчинд үзүүлэх хор хөнөөлийг бууруулах, уур	<p>1.5а Төслийн хугацаанд төслийн хэрэгжилтээс үүдэн байгаль орчинд учирч болзошгүй аюул заналыг тодорхойлж, түүнийг бууруулах арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлнэ.</p> <p>1.5б Төслүүд нь экосистемийн хандлагыг (жишээ нь, байгальд суурилсан шийдлүүд) ашиглан экосистемийн</p>



амьсгалд тэсвэртэй байдлыг дэмжих нь төслийн боловсруулалт, хэрэгжилтийг удирдан чиглүүлнэ.	үйлчилгээний хүртээмжийг сайжруулахыг эрэлхийлэх ёстой. 1.5в Байгууллагууд төслийн хэрэгжилтийн нүүрстөрөгчийн хийн ялгаруулалтыг хамгийн багадаа бүх олон улсын аялал, орон нутгийн тээвэрт жил бүр тооцож; уг тооцооллыг боломжтой бол нүүрстөрөгчийн хийн ялгаруулалтыг багасгах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахад ашиглана.
---------------------------------------------------------------------------------------------	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

## ЧИГЛЭЛ 2: ХЭРЭГЖИЛТ

**Тайлбар:** Хөгжлийн төлөөх сайн дурын үйл ажиллагааны төслийн үр нөлөөтэй, хариуцлагатай төслийг хэрэгжүүлж, удирдан чиглүүлэх нь төслийн анхны боловсруулалтыг биелүүлж, хяналт тавихад олон нийтийг оролцуулна.

	Гол арга хэмжээ	Үзүүлэлтүүд
2.1 Үндсэн	Төсөлд хамрагдсан хүн бүрийн аюулгүй, амжилттай ажиллах орчныг бүртгүүлэх төслийн удирдлагаар хангах.	2.1а Төсөлд хамрагдсан бүх хүмүүс, түүний дотор хэрэгжүүлэгч түнш байгууллагууд, тэдгээрийн ажилтнууд, түүнчлэн сайн дурынхан төслөөс хүсэн хүлээсэн үр дүнг мэддэг, түүнд хүрэхийн тулд нэг баг болон үр дүнтэй хамтран ажиллахаар зорьсон байна. 2.1б Бүх түнш ажилтнууд, сайн дурынхан төслийн талаарх асуултад хариулж, өөрсдийн Зорилт хариуцлагатай холбоотой шийдвэр гаргах эрх мэдлийг мэдрэх боломжтой. 2.1в Бүх түнш ажилтнууд сайн дурынхны үр чадвар, эрч хүч, санаа бодлыг нэмэгдүүлэхийн тулд сайн дурынхныг дэмжих орчныг бүртгүүлнэ.
2.2	Олон нийтийн гишүүдийн байнгын оролцоог баталгаажуулна.	2.2а Олон нийтийн гишүүд асуудал, гомдлыг өөрийн хэл дээр мэдээлэх журамтай танилцаж, сайн дурын ажилтны зан үйлд сэтгэл дундуур байгаа шалтгаан байвал үүнийг идэвхтэй мэдээлэх эрхтэй. 2.2б Олон нийт төслийн ба сайн дурынхны ажлын талаар санал бодлоо тогтмол илэрхийлэх боломжтойг баталгаажуулсан байна. 2.2в Олон нийтийн гишүүд төслийн түршид хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцоно. 2.2г Байгууллагууд гадуурхагдсан, эмзэг бүлгийн хүмүүсийг (эрэгтэй/эмэгтэй/бусад, гэрлэсэн/гэрлээгүй, боловсролтой/боловсролгүй, хөгшин/залуу гэх мэт) төсөлд хамруулна.
2.3	Төсөлд саад учруулах, шинээр гарч ирж буй эрсдэлийг (сайн дурынхны зан байдал, байгалийн	2.3а Байгууллагууд төсөлд гарсан тасалдал болон удирдлагаас авсан хариу арга хэмжээний бүртгэл хөтөлнө. 2.3б Байгууллагууд осол, гаднын эрсдэл, аюулд хариу арга хэмжээ авах бэлэн байдлыг тогтмол хянана.

	гамшиг, харилцаа холбоо) зохицуулах журамтай байна.	
2.4	Төслийн туршид хяналт тавих, суралцах тогтвортой системийг дагаж мөрдөнө.	2.4а Байгууллагууд төсөлд тогтмол хяналт тавьж, үнэлгээ хийнэ. 2.4б Байгууллагууд үнэлгээний үр дүнг ашиглан төслийн хэрэгжилтийг тохируулж, шаардлагатай сайжруулалтыг хийх замаар үйл ажиллагаагаа сайжруулахад суралцана.

### ЧИГЛЭЛ 3: ХЯНАЛТ БА ХААЛТ

**Тайлбар:** Үр дүнтэй хөгжлийн төлөөх сайн дурын үйл ажиллагаа явуулахын тулд төслийн үр нөлөө болон ирээдүйн төслүүдэд сургамж болох нотолгоог хангаж, төслийн дуусгаварыг хийх хэрэгтэй.

	Гол арга хэмжээ	Үзүүлэлтүүд
3.1	Төсөл, түншлэлийг ил тод, оролцоотойгоор дуусгавар болгох тодорхой хаалтын стратегийг боловсруулна.	3.1а Байгууллагууд төслийг хаах тодорхой стратегийг боловсруулж, баримтжуулна. 3.1б Байгууллагууд төслөөс суралцсан зүйлийг бүртгэж баримтжуулна. 3.1в Байгууллагууд төслийн дараах үнэлгээг төлөвлөнө.
3.2 Үндсэн	Төслийн нийт үр нөлөөг олон нийттэй нягталж, үр дүнгээс суралцахын тул үнэлгээ хийнэ.	3.2а Олон нийтийн гишүүд, байгууллагууд, сайн дурынхан болон бусад оролцогч талууд төслийн хяналт, үнэлгээ, суралцах үйл явцад оролцоно. 3.2б Төслийн үйл ажиллагааны баримтжуулалт болон суралцах суралцах үйл явцыг олон нийтэд танилцуулна. 3.2в Байгууллагууд үнэлгээний үр дүнг - амжилт болон бэрхшээлүүдийн аль алиныг нь - дотоод ба гадаадын бүх оролцогч талуудтай хуваалцана.
3.3	Олон нийт, сайн дурын ажилтны хувийн хөгжилд оруулах хувь нэмрийг судалж, ойлгоно.	3.3а Байгууллагуудад сайн дурынхны оруулсан хувь нэмрийг өөрийгөө тайлагнах болон хөндлөнгийн үнэлгээг хослуулан хянах хяналтын систем, механизмтай байна. 3.3б Хяналтын систем нь сайн дурын ажилтнуудын тайлангаас ирсэн санал хүсэлт байгууллагын үйл ажиллагааг мэдээлэх, хянах тодорхой, идэвхтэй дотоод харилцааны төлөвлөгөөг агуулна. 3.3в Байгууллагууд үр нөлөөний хяналт болон үнэлгээг ирээдүйн сайн дурын төсөл болон ажлын байрыг төлөвлөхөд ашиглана.

## ХАЛАМЖИЙН ҮҮРЭГ

**Зорилт:** Байгууллагууд болон тэдэнтэй холбоотой хүмүүс сайн дурынхан эсвэл орон нутгийн гишүүдээс үл хамааран өөрсдийн үйл ажиллагаа явуулж буй нутаг дэвсгэрт хэнийг ч хамгаалж, хор хөнөөл учруулахыг зөвшөөрөхгүй гэж олон нийт найдаж болно. Байгууллага нь сайн дурын ажилтан, ажилчин болон бусад хамтрагчиддаа сэтгэл зүйн болон бие махбодийн хохирол учруулахгүй байх, урьдчилан сэргийлэхэд анхаарах үүрэгтэй гэдгээ хүлээн зөвшөөрнө.

**Хамрах хүрээ:** Олон нийтийн гишүүд, сайн дурынхныг аюулгүй, хор хөнөөлөөс ангид байлгахын тулд сайн дурынхантай ямар ч хугацаанд хамтран ажиллаж буй байгууллага, түншүүд үүнийг хангасан байх ёстой.

### ЧИГЛЭЛ 4: АЮУЛГҮЙ БАЙДАЛ

**Тайлбар:** Байгууллага нь сайн дурынхан болон олон нийтийн аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй эрсдэлийг ойлгох, үнэлэх, бууруулах үүрэгтэй.

	Гол арга хэмжээ	Үзүүлэлтүүд
4.1 Үндсэн	Сайн дурынхан болон олон нийтэд нөлөөлж болзошгүй аливаа эрсдэлд байгууллагын тэсвэрлэх чадварыг тодорхойлох.	4.1а Байгууллага нь сайн дурынхны ажиллаж эхлэхээс өмнө Аюулгүй байдлын бодлого, дүрэм журмаа гаргасан байна. 4.1б Байгууллагууд олон нийт болон сайн дурынханд нөлөөлж болзошгүй эрсдэлийг тэсвэрлэх чадвартай гэдгээ олон нийтэд нээлттэй мэдэгдэх тодорхойлолттой байна.
4.2	Төслийн төлөвлөлт, төсөв боловсруулах явцад эрсдэлийг таньж мэдэх, тэдгээрийг бууруулах.	4.2а Байгууллагууд аюулгүй байдлыг урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, даатгал болон Аюулгүй байдлын асуудал хариуцсан орон нутгийн ажилтан зэргийг хамруулсан төсөвтэй байна. 4.2б Аюулгүй байдлын сургалтад хамрагдсан ажилтнууд боловсруулалтын төлөвлөгөөг хянах эсвэл төсөл боловсруулж буй ажилтнууд аюулгүй байдлын сургалтад хамрагдсан байна.
4.3 Үндсэн	Холбогдох эрсдэлийн үнэлгээг сайн дурынхан, ажилтнууд болон олон нийттэй хуваалцаж, ажил эхлэхээс өмнө тэднээс оролцох зөвшөөрлийг авах.	4.3а Байгууллагууд эрсдэлийн үнэлгээ хийж, шинэ байршил болон ашигласан тээврийн маршрут бүрт нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөг тусгах бөгөөд эдгээр нь тодорхой давтамжтайгаар шинэчлэгдэж байна. 4.3б Байгууллагууд сайн дурын ажилтны талаарх холбогдох мэдээллийг цуглуулж, сайн дурын ажилтан оролцох сонголтоо хийсэн гэсэн нотлох баримтыг хадгална. 4.3в Сайн дурынхан өөрт тохиолдох эрсдэлийг удирдах талаар ажилд орохоос өмнөх сургалтад хамрагдана. 4.3г Олон нийт аливаа шинэ/үүсэж буй эрсдэлийг

		байгууллагад хэрхэн мэдээлэх талаар мэдлэгтэй байна.
4.4	Сайн дурынхны ажлын байрны аюулгүй байдлыг хянах.	<p>4.4а Сайн дурынхан ажиллаж эхлэхийн өмнө тодорхой эрсдэл болон эрсдэлийг удирдахад тэдний гүйцэтгэх үүргийн талаарх сургалт болон урт хугацааны ажлын явцад аюулгүй байдлын шинэчилсэн сургалтуудад тус тус хамрагдана.</p> <p>4.4б Байгууллагууд төсөл, олон нийт эсвэл сайн дурынханд нөлөөлж болзошгүй аюулгүй байдлын эрсдэлд хяналт тавих, сайн дурынхан, орон нутгийн иргэдэд аялал жуулчлалын талаар зөвлөгөө өгөх, гол асуудлуудыг мэдээлэх үүрэгтэй хувь хүнийг тодорхойлно.</p> <p>4.4в Байгууллагууд сайн дурын ажилтан болон орон нутгийн иргэдийн ахлагчийг бүртгэх системтэй байна.</p>
4.5 Үндсэн	Аюулгүй ажиллагааны цогц төлөвлөгөө боловсруулж, дагаж мөрдөнө.	<p>4.5а Байгууллага болон хамтран ажиллагсад нь гол эрсдэлүүдийг бууруулахын тулд Аюулгүй байдлын төлөвлөгөөг уншиж ойлгох шаардлагатай бөгөөд болзошгүй бүх ослын тохиолдолд хэрхэн хариу үйлдэл үзүүлэх заавартай байна.</p> <p>4.5б Байгууллага болон хамтран ажиллагсад нь яаралтай үеийн харилцааны төлөвлөгөөтэй танилцаж, ойлгосон байна.</p> <p>4.5в Байгууллагууд нь зөрчлийг мэдэгдэх стандарт, үйл явцыг тодорхойлсон байна.</p> <p>4.5г Байгууллагууд нь зөрчлийн дараах үнэлгээ, хяналтын нотлох баримтуудтай ажиллаж баримтжуулан хадгалдаг байна.</p>

### ЧИГЛЭЛ 5: ХАМГААЛАХ БА УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

**Тайлбар:** Байгууллага нь хүн бүр аюулгүй байх эрхтэй гэдгээ мэдэх, мэдрэх боломжоор хангаж, сайн дурын, хөгжлийн хөтөлбөрт оролцож буй хүн бүрийн, тэр дундаа хүчирхийлэл, аюул заналд учирсан хүүхэд, насанд хүрэгчидтэй ажилласан сайн дурын ажилтнуудын аюулгүй байдлыг хангасан байх шаардлагатай.

	Гол арга хэмжээ	Үзүүлэлтүүд
5.1 Үндсэн	Хамгаалах, хамгаалах эрсдэлийг бууруулах бодлого, журам, сургалт, хариуцлагын механизмыг бий болгох.	<p>5.1а Байгууллага нь хүүхэд хамгаалал, хүчирхийллийн талаарх ойлголтыг тодорхойлсон хүүхэд хамгааллын бодлого, удирдамж нь олон нийтэд нээлттэй байх бөгөөд түүнийг хэрэгжүүлдэг байна.</p> <p>5.1б Үндсэн, гэрээт болон сайн дурын ажилтнууд нь өөр хоорондоо болон эмзэг өртөмтгий хүүхэд, насанд хүрэгчид рүү чиглэсэн зохисгүй үйлдэл гаргахаас сэргийлсэн шүгэл үлээх бодлого, удирдамж, сахилга шийтгэлийн журам, тайлагнах арга хэлбэрийн талаар мэдээлэлтэй байна.</p> <p>5.1в Үндсэн болон сайн дурын ажилтнууд нь хүүхэд, эмзэг өртөмтгий насанд хүрэгчдийг хамгаалах, урьдчилан</p>

		<p>сэргийлэх бодлого журмын талаар холбогдох сургалтад хамрагдана</p> <p>5.1г Байгууллага нь хамгаалалтын үйл ажиллагааны эрсдэлийн үнэлгээг жилд багадаа нэг удаа эсхүл сайн дурын ажилтан солигдох бүрт хийнэ.</p> <p>5.1д Хамгаалалтын үйл ажиллагаанд томилогдсон ажилтан эсхүл үүрэг хүлээгч үйл явцыг хянанана.</p>
5.2 Үндсэн	Бүхий л орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангах сайн дурын үйл ажиллагааг дэмжих үүрэг хүлээнэ.	<p>5.2а Байгууллагын хүүхэд хамгааллын Зорилтт хүчирхийлэлд хариу үзүүлэх, түүнээс сэргийлэх ажлыг бүтэцлэх, хэмжих ажлууд багтана.</p> <p>5.2б Байгууллага нь хүүхэд бүр, залуу хүн бүр ижил тэгш байдлаар асаргаа үйлчилгээ авч байгаа эсэхийг бататгахын зэрэгцээ тэд бүгд өөрчлөлтийг түүчээлэгч болохыг ч мөн бататгана.</p> <p>5.2в Байгууллага нь сайн дурын ажилтнуудыг асрамжийн газар болон бусад ижил үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудтай хамтран ажиллахыг зөвшөөрдөггүй;</p> <ul style="list-style-type: none"> <li>- Байгууллага нь асрамжийн газар болон бусад халамжийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай аялал жуулчлалын хөтөлбөрт хамтран ажилладаггүй;</li> <li>- Байгууллага нь асрамжийн газар болон хүүхдийн халамжийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагад нэг удаа эсвэл богино хугацаагаар очихыг зөвшөөрдөггүй.</li> </ul>
5.3	Сайн дурын нийт ажилтан бөгөөд тэдэнтэй холбогдох бүх хүмүүсийн аюулгүй байдлыг ханган ажиллана.	<p>5.3а Байгууллага нь зохих үр чадвартай, мэргэшсэн, түршлагатай ажилтануудаар дамжуулан сайн дурынханд хүүхэд хамгаалал, урьдчилан сэргийлэх талаар олон нийтийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагын тухай урьдчилан болон байнгын сургалтанд хамруулж байна.</p> <p>5.3б Байгууллага нь зохисгүй зохицуулалт, хүчирхийлэл, дээрэлхэлтийг таньж мэдэх, тайлагнан мэдэгдэх, хариу арга хэмжээ авахдаа хийж болох болон болохгүй үйлдлийг тодорхойлсон удирдамжаар хангана.</p> <p>5.3в Хамтрагч байгууллагууд хүчирхийллээс хамгаалах үед үүсэж болох аливаа асуудлыг тайлагнахтай холбоотой алхам бүрчлэн зааварчилсан удирдамжийг бүх нийтэд нээлттэйгээр байршуулан, баримтжуулсан журамтай байна.</p>
5.4	Төсөлд оролцож буй сайн дурын ажилтнууд хоорондоо болон бусадтай эв нэгдэлтэй, нэг нэгэндээ хүндэтгэлтэй	<p>5.4а Байгууллагууд олон нийт болон түншүүдийн хоорондын харилцаанд хүний эрхэд суурилсан Ёс зүйн дүрэм эсвэл багц журмыг танилцуулж, хэрэгжүүлнэ.</p> <p>5.4б Байгууллагууд мессеж, зураглал, тэр дундаа хүүхдүүдтэй холбоотой бодлого, удирдамжийг боловсруулж хэрэгжүүлэх бөгөөд энэ нь орон нутгийн иргэд, хувь хүмүүсийг үнэн зөв дүрсэлж, эрсдэлд</p>

	хандахыг уриалах, дэмжих, явцын байдлыг хангах.	оруулахгүй, сенсаацлах, хэвшмэл ойлголт өгөхгүй байхыг баталгаажуулна. 5.4в Байгууллага нь хүүхэд, залуучууд, насанд хүрэгчдэд хамаатай шийдвэрт идэвхтэй, утга учиртай оролцох боломжийг олгоно.
5.5	Сайн дурынхан болон тэдэнтэй харилцдаг хүмүүсийн олон талт байдал, хувь хүний онцлогт шаардлагатай хамгаалалт, дэмжлэгийн хэрэгцээг хангах.	5.5а Байгууллага нь төслийн бүх үе шатанд тэгш байдал, тэгш оролцоо, хүртээмжтэй болон олон талт байдлыг хангана.  5.5.б Байгууллага нь хөдөлмөрийн мөлжлөг, хүнтэй зүй бусаар харилцах, дарамтлах, дээрэлхэх үйлдлийг таньж мэдэх, урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах журамтай байна.
5.6 Үндсэн	Байгууллага болон түүний бүхий л үйл ажиллагаанд бэлгийн мөлжлөг, хүчирхийлэл, дарамт, хүйсийн ялгаанд суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авахыг үүрэг болгох.	5.6а Өмнө нь бэлгийн мөлжлөг, хүчирхийлэл, заналхийлэл, жендерт суурилсан хүчирхийлэл үйлдэж байсан этгээдийг сайн дурын ажилтнаар элсүүлэх эрсдэлийг бууруулах зорилгоор хувийн болон/эсвэл мэргэжлийн тодорхойлолт, захидал авах, эрүүгийн болон/эсвэл гэр бүл, ажил байдлын шалгалт хийнэ. 5.6б Үндсэн болон сайн дурын ажилтнуудын Ёс зүйн дүрэмд бэлгийн мөлжлөг, хүчирхийлэл, заналхийлэл, жендерт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зан төлөвийн хэм хэмжүүрийг тодорхойлон тусгасан байна. 5.6в Үндсэн болон сайн дурын ажилтнууд бэлгийн мөлжлөг, хүчирхийлэл, заналхийлэл, жендерт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах Зорилт хариуцлага, үйл ажиллагааны талаар тогтмол сургалтад хамрагдана. 5.6г Бэлгийн мөлжлөг, хүчирхийлэл, заналхийлэл, жендерт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үүрэгтэй ашиг хүртэгч бүлгийн тусламжтайгаар олон нийтэд таниулах; бэлгийн мөлжлөг, хүчирхийлэл, заналхийлэл, жендерт суурилсан хүчирхийлэлд өртсөн хүмүүст гарын үсэг зурсны дараа тайлагнах, тусламж үзүүлэх зэрэг багтана.

## ЧИГЛЭЛ 6: ЭРҮҮЛ МЭНД & ЭРҮҮЛ ОРШИХУЙ

**Тайлбар:** Хувь хүн, байгууллага, олон нийтийн гишүүдтэй хамгийн сайн үр дүнтэй ажиллахын тулд байгууллагууд сайн дурынхан болон хамт олны эрүүл мэнд, эрүүл оршихуй, сэтгэл санааны болон сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах байдлыг ажилд авахаас өмнө, ажлын үеэр болон дараа нь хангаж ажиллах ёстой

	<b>Гол арга хэмжээ</b>	<b>Үзүүлэлтүүд</b>
--	------------------------	--------------------

6.1 Үндсэн	Байгууллагатай хамтран ажиллаж байгаа сайн дурын ажилтнуудын эрүүл мэнд, эрүүл оршихуйг төслийн турш үнэлэн, дэмжиж ажиллана.	<p>6.1a Байгууллага сайн дурын ажилтныг ажилд авахын өмнө, дараа болон хөтөлбөрийн үеэр тэдний эрүүл мэнд, эрүүл оршихуйг өөрчилж болзошгүй нөлөөллийг бууруулах тогтолцоог бий болгоно</p> <p>6.1б Байгууллагууд эрүүл мэнд, эрүүл оршихуйн талаар ажилд авахаас өмнө сургалт явуулна. Үүнд дараах зүйлс багтана:</p> <ul style="list-style-type: none"> <li>-Нийтлэг тохиолддог бухимдлын хэлбэр болоод түүнийг хэрхэн даван туулах тухай</li> <li>-Нийтлэг тохиолддог эрүүл мэндийн бэрхшээл, түүнээс хэрхэн сэргийлэх тухай.</li> <li>-Өөрийн сэтгэцийн эрүүл мэндийг хэрхэн удирдах тухай, бусдаас тусламж хэрэгтэй болсон үед хаана хэнд хандах тухай.</li> </ul>
6.2	Сайн дурын ажилтнуудад (мөн хэрэв төслийн хувьд эрүүл мэндийн чиглэлийн зорилт байгаа бол, олон нийтийн гишүүдэд) бие, сэтгэцийн эрүүл мэндийн эерэг дадлыг түгээнэ.	<p>6.2a Сайн дурын ажилтнуудтай ажилладаг бүх байгууллага, хамтрагч байгууллагын ажилтнууд сайн дурын ажилтны эрүүл мэнд, эрүүл оршихуйг сайн дурын хөтөлбөрийн явцад хянах үүрэгтэй.</p> <p>6.2б Байгууллагууд эрүүл мэндийн асуудлыг (сэтгэцийн эрүүл мэндийг хамруулан) илрүүлж, анхны тусламж үзүүлж, зохих үйлчилгээ үзүүлэгчдэд шилжүүлэх ажилтныг томилно.</p> <p>6.2в Байгууллагууд бие бялдар, сэтгэцийн эрүүл мэнд, тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй холбоотой сэтгэлийн шархыг эмчлэх, сайн дурын ажилтан сэтгэцийн болоод бие махбодын бэрхшээлээс үүдэлтэй сэтгэл зовнилтой үед ямар арга хэмжээ авах талаарх сургалтад холбогдох ажилтнуудыг хамруулж байгаа эсэхийг баталгаажуулна.</p>
6.3	Хүүхэд, эмзэг бүлгийн насанд хүрэгчид болон олон нийтийн эрүүл мэнд, сайн сайхан байдалд сайн дурын хөтөлбөрийн үр нөлөөг тооцолдог байна.	<p>6.3a Байгууллагад сайн дурынхны ажиллах хугацаанд эмзэг өртөмтгий бүлгийн хүүхдүүдийн эрүүл оршихуй, эрүүл мэндийн байдлыг дордуулахгүй байхад анхаарсан бодлого, удирдамжийг тодорхойлсон байна.</p> <p>6.3б Байгууллагууд эрсдэлийн үнэлгээнд хүүхэд, эмзэг өртөмтгий бүлгийн насанд хүрэгчид болон бусад нийгмийн бүлгэмийн бие бялдар, сэтгэцийн эрүүл мэндэд учирч болох эрсдэлийг ч мөн багтаана.</p> <p>6.3в Байгууллагууд нь хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын Удирдамжид орон нутгийн бүлгүүдийн эрүүл аюулгүй байдалд дасан зохицох хөтөлбөрийн үр нөлөөг тусгасан байна.</p> <p>6.3г Сайн дурын ажилтнууд дээрэлхэх, ялгаварлан гадуурхлын талаарх байгууллагын байр суурийг ойлгож, ажлаа эхлүүлэхээс өмнө тэгш эрх, дээрэлхэлтийн эсрэг тэмцэх талаар цахим болон танхимын сургалтад хамрагдана.</p>

## САЙН ДУРЫНХНЫГ УДИРДАХ

**Зорилт:** Сайн дурын ажилтнууд орон нутгийн болон олон улсын хэмжээнд хөгжлийн хүчин чармайлтыг дэмжихэд үр дүнтэй, байнгын оролцоог бататгах бэлтгэл, сургалт, дэмжлэг авах боломжтой.

**Хамрах хүрээ:** Энэ нь сайн дурын ажилтнууд болоод тэдэнтэй хамтран ажилладаг байгууллагуудад ч мөн хамаарна. Энэ нь орон нутгийн, үндэсний, олон улсын болон цахимаар ажиллаж байгаа сайн дурын ажилтнуудад хамаарна. Энэ нь сайн дурын ажлын замналын бүхий шатанд бүтэцлэгдсэн хүрээгээр хангах болно.

### ЧИГЛЭЛ 7: АЖИЛД АВАХ & СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ

**Тайлбар:** Олон нийтийн тодорхойлсон хэрэгцээг хангахын тулд сайн дурын ажилтнуудыг тогтсон шалгуураар сонгон шалгаруулж авна.

	Гол арга хэмжээ	Үзүүлэлтүүд
7.1 Үндсэн	Сайн дурынхныг ажилд авах байгууллагын зорилго, үнэт зүйл, үйл ажиллагаа нь тодорхой байх.	7.1а Байгууллагуудын сайн дурын үйл ажиллагааны бодлого, удирдамж нь сайн дурын ажилтан элсүүлэх үйл ажиллагаа, холбоо хамааралтай зорилго зорилт, зорилго зорилт, хариуцлага, үйл ажиллагааг тодорхойлно. 7.1б Байгууллага болон хамтрагч байгууллагын ажилтнууд сайн дурын ажилтныг сонгон шалгаруулах, дасан зохицуулахтай холбоотой зорилго, үнэ зүйл, үйл явцыг ойлгоно. 7.1в Байгууллагын бодлого, журам, маркетинг нь сайн дурынхны өргөдөл гаргах эсвэл амжилттай оролцохыг ялгаварлан гадуурхах аливаа саад бэрхшээлийг арилгана.
7.2	Маркетингийн кампанит ажил нь сайн дурын ажлын туршлагын бодит байдлыг таниулан, олон төрлийн сайн дурынхан, ялангуяа бага төлөөлөлтэй бүлгүүдэд хүрч үйлчлэх.	7.2а Боломжит сайн дурын ажилтнуудад сайн дурынхны туршлага, түнш болон байгууллагын харилцааг бодитоор дүрслэн харуулна. 7.2б Байгууллага нь дутуу төлөөлөгдсөн бүлгэм болоод бусад ялгаатай олон бүлгэмээс сайн дурын ажилтан элсүүлэхийг идэвхтэй эрэлхийлнэ. 7.2в Байгууллагын маркетинг нь сайн дурын ажилтнуудад өөрсдийн зорилгыг ойлгох, тэдний үүрэг оролцоо нь бүлэг болон хамтрагч байгууллагуудын хүлээлтэд нийцэж байгааг ойлгоход тусална.
7.3	Хэрэгцээ шаардлагын үнэлгээнд суурилсан, шаардлагатай дэмжлэгийг	7.3а Бүлгийн гишүүд, гол оролцогч талууд, хамтрагч байгууллагууд төсөлд шаардлагатай сайн дурын ажилтанд тавигдах шаардлагыг тодорхойлно. 7.3б Сайн дурын ажилтнууд өөрсдийн ажил үүргийн тодорхойлолтоос, ямар дэмжлэг шаардлагатай байгаа,



	тодорхой заасан ажил үүргийн тодорхойлолтыг бий болгох.	хэний дэмжлэгтэй ажиллаж байгааг, ямар нөхцөлөөр ажиллаж байгааг мэдэх боломжтой байна. 7.3в Сайн дурын ажилтнууд нь өөрийн гүйцэтгэх Зорилт, хүлээх хариуцлагын талаар бүрэн мэдээлэлтэй байна. 7.3г Төсөлд оролцох хүн бүр өөрсдийн Зорилт хариуцлагыг мэдэхийн зэрэгцээ бусад гишүүдтэй холбоотой Зорилт оролцоогоо мэддэг байна.
7.4 Үндсэн	Боломжит нэр дэвшигчийг стандартын дагуу сонгон шалгаруулж бүрэн төлөөлөгдөж чадаагүй бүлгэмийн оролцоог ижил тэгш хангах орон зайг үлдээсэн байна.	7.4а Боломжит нэр дэвшигч нь сонгон шалгаруулалт болон үүрэг хариуцлагын талаарх тодорхой мэдээллээр ил тодоор хангагдана. 7.4б Байгууллагын ажилтны үнэлгээ <ul style="list-style-type: none"> <li>- Бүлгийн хэрэгцээ, хамтрагч байгууллагын хэрэгцээ, сайн дурын ажилтны үүрэг оролцоо, уялдаа холбоотой байна;</li> <li>- Зөөлөн үр чадвар болон техникийн үр чадвар;</li> <li>- Соёл хоорондын ялгааг ойлгодог байх;</li> <li>- Сайн дурын ажилтнаар өмнө нь ажиллаж байсан туршлагатай байх;</li> <li>- Ажлын байр болон бодит байдлын талаар мэдээлэлтэй, ойлголттой байх.</li> </ul> 7.4в Байгууллагын үнэлгээ, шалгаруулалтын арга нь хамтрагч байгууллагын зааварчилгааны дагуу байж, шаардлагатай тохиолдолд тэдэнд ч сонгон шалгаруулалтын үнэлгээнд ижил тэгш оролцох боломжоор хангана 7.4г Байгууллага нь хувь хүний болоод мэргэжлийн тодорхойлолт шаардах ба гэмт хэрэгт холбогдож байгаагүй тухай лавлагаа, хүүхэд хамгааллын бусад шалгалтыг хийнэ. 7.4д Байгууллага сайн дурынхны эрүүл мэндийг үнэлэх боломжтой байна.

## ЧИГЛЭЛ 8: БЭЛТГЭЛ & СУРГАЛТ & СУРАЛЦАХУЙ

**Тайлбар:** Ажлын байрны үр нөлөөг нэмэгдүүлэхийн тулд сайн дурынхан, түншүүдэд үзүүлэх ажлын өмнөх дэмжлэг, сургалт нь сайн дурынхан сайн бэлтгэгдсэн байх баталгаа болно.

	Гол арга хэмжээ	Үзүүлэлтүүд
8.1 Үндсэн	Сайн дурынхан, түншүүдийг сайн дурын ажилтны ажилтай холбоотой бүх бодлого, журамтай танилцуулах.	8.1а Сайн дурынхан бодлого, журмын хуулбарыг бичгээр эсвэл цахимаар хүлээн авах бөгөөд тэдгээрийг ажиллаж байх хугацаандаа ашиглах боломжтой. 8.1б Сайн дурынхан байгууллагатай ажиллах хугацаандаа эдгээр бодлогыг дагаж мөрдөхийг зөвшөөрч гарын үсэг зурна.

		<p>8.1в Түншүүд сайн дурынхны ажилд зохих ёсоор дэмжлэг үзүүлэхийн тулд холбогдох бүх бодлого, журамтай танилцсан байна.</p> <p>8.1г Түншүүд ажил эхлэхээс өмнө сайн дурынхны дэмжлэг, менежменттэй холбоотой бүх бодлогыг нийцүүлэн баталгаажуулна.</p>
8.2 Үндсэн	<p>Сайн дурын ажилтныг байршуулахаас өмнө түншүүд бие биенийхээ үүрэг, хариуцлагын талаар тодорхой ойлголттой байгаа эсэхийг баталгаажуулж, түншүүдийн хоорондох бодит хүлээлтийг тохиролцох.</p>	<p>8.2а Түншүүд сайн дурынхны оролцооны чадавх болон үзүүлэх үр нөлөөний талаар тодорхой ойлголттой байна.</p> <p>8.2б Түншүүд сайн дурын ажилтны ёс зүйн дүрмийг ойлгож, түүнд хяналт тавихад дэмжлэг үзүүлнэ.</p> <p>8.2в Түншүүд сайн дурынхнаас аль болох их үр өгөөж авахын тулд тэдний зан байдал, хандлага, сэтгэлгээний талаар тодорхой хүлээлттэй байна.</p> <p>8.2г Түншүүдэд нийгэм, соёлын аливаа мэдрэмтгий байдлын талаар анхааруулж, ойлгуулах ёстой.</p>
8.3	<p>Ажлын өмнөх болон ажлын байран дээрх сургалт болон сургалтын материал нь шинэчлэгдсэн, үнэ төлбөргүй, хамааралтай, хүртээмжтэй, суралцах арга барил нь өөр төрөл бүрийн сайн дурынханд тохиромжтой байх.</p>	<p>8.3а Сайн дурынхан шаардлагатай сургалтад хамрагдаж, олж авсан үр чадвар, мэдлэгээ хэрэгжүүлэх чадвартай гэдгээ харуулна.</p> <p>8.3б Байгууллагын ажилтнууд чанартай, хамааралтай, хүртээмжтэй байдлыг хангахын тулд түнш бүрийн сургалтын үйл явц, агуулгыг болон сайн дурын ажилтнуудтай холбоотой бодлогыг шаардлагатай үед тогтмол хянаж, шинэчилнэ.</p>
8.4	<p>Сайн дурынханд ажлын нөхцөл байдлын талаар танилцуулах.</p>	<p>8.4а Сайн дурынхан хөгжлийн төлөөх сайн дурын үйл ажиллагааны салшгүй сорилт, хөгжлийн асуудлын харилцан уялдаа холбоо (жишээлбэл, уур амьсгалын өөрчлөлт, боловсрол, эрүүл мэнд, ядуурал гэх мэт), тэдний ажил Тогтвортой хөгжлийн зорилтуудад хэрхэн нөлөөлж байгаа талаар тодорхой ойлголттой байна.</p> <p>8.4б Сайн дурынханд тэдний ажиллаж буй төслийн хөгжлийн зорилтууд, төслийг хэрхэн боловсруулсан, тэдний оролцоо энэ төсөлд хэр үр өгөөжтэй зэрэг мэдээллийг өгнө.</p>

		8.4в Сайн дурынханд илүү өргөн хүрээтэй байгууллага, түүний зорилго, үнэт зүйлс болон төсөл нь байгууллага, түүний түншүүдийн өргөн хүрээний эрхэм зорилго, алсын хараатай хэрхэн нийцэж байгаа талаар танилцуулна.
8.5 Үндсэн	Сайн дурын ажилтнууд өөрсдийн үүрэг, тэднээс хүлээгдэж буй зан байдал, орон нутгийн нөхцөл байдлын талаар тодорхой ойлголттой байгаа эсэхийг баталгаажуулахын тулд ажилд орохын өмнө тэдэнтэй бодит хүлээлт үүсгэх.	<p>8.5а Сайн дурынхан өөрсдийн оролцооны нөлөө, урт хугацааны зорьж буй үр дүн, хөгжлийн төлөө сайн дурын үйл ажиллагаа явуулах төслийн дасан зохицох шинж чанарын тодорхой ойлголттой байна.</p> <p>8.5б Сайн дурынхныг ижил төстэй төсөл дээр ажиллаж байсан сайн дурынхантай, боломжтой бол орон нутгийн ажилтнуудын багийн гишүүдтэй ярилцахыг дэмжинэ.</p> <p>8.5в Сайн дурынхан ажилд орохдоо Ёс зүйн дүрэмд гарын үсэг зурж, дагаж мөрдөнө. <i>Чиглэл 2 Төсөл боловсруулах, хэрэгжүүлэх, Үзүүлэлт За ба 3б-ийн холбоос.</i></p> <p>8.5г Сайн дурынханд сайн дурын ажлыг үр дүнтэй явуулах хамгийн сайн зан байдал, хандлага, сэтгэлгээний талаар ойлгуулж, ярилцах цаг өгнө.</p> <p>8.5д Сайн дурынханд тэдний ажилтай холбоотой нийгэм, соёлын аливаа мэдрэмтгий байдлын талаар ойлголт өгнө.</p> <p>8.5е Сайн дурынхан сайн дурын ажил хийх газар нутгийн соёлын талаар нарийвчилсан танилцуулга, сургалтад хамрагдана.</p> <p>8.5ё Сайн дурынхан ирсэн даруйдаа ямарваа нэгэн тусламжтай эсвэл тусламжгүйгээр байрлах байранд аюулгүйгээр шилжин суурьшихад туслах тодорхой нэгдсэн заавар, холбоо барих хаягтай байна.</p> <p>8.5ж Сайн дурынханд ажил дээрх нийгэм, санхүүгийн үр дагаврын талаар мэдээлэл ойлголт өгнө.</p>

## ЧИГЛЭЛ 9: АЖЛЫН БАЙР & ДЭМЖЛЭГ

**Тайлбар:** Үр нөлөө бүхий ажлын байраар хангагдахын тулд сайн дурынхан үр дүнтэй мэргэжлийн болон хувийн дэмжлэг авна.

	Гол арга хэмжээ	Үзүүлэлтүүд
9.1 Үндсэн	Байгууллага, түнш болон бүх сайн дурынхны хоорондын үүрэг, хариуцлагыг тодорхой болгоно.	<p>9.1а Түншүүд хэрэгцээний үнэлгээнээс эхлээд ажлын төгсгөл хүртэлх холбогдох үе шатыг хамарсан тус тусын үүрэг, хариуцлагыг тодорхой болгохын тулд байгууллагуудтай гэрээ байгуулна.</p> <p>9.1б Сайн дурынхан, түнш, байгууллагууд ажил үүргийн хариуцлагыг тодорхой болгож, ажлын нөхцөлийг тусгасан гэрээг хянаж гарын үсэг зурна.</p>

		<p>9.1в Сайн дурынхан өөрсдийн гэрээний нөхцөлийг ойлгож, тэдгээрийг тууштай, ил тод, тэгш байдлаар хэрэгжүүлэх хэрэгтэй.</p> <p>9.1г Байгууллагууд аюулгүй байдал, хамгаалалт, эрүүл мэнд, сайн дурын ажилтны оролцоо, сайн дурын ажилтны менежментийн талаар түнш болон ажилтнуудад байнгын дэмжлэг үзүүлнэ.</p> <p>9.1д Сайн дурынхан ажлын эхэнд ажлын байр, орон нутгийн нөхцөл байдал, хамтрагчид болон олон нийтийн талаар чиг баримжааны сургалтад хамрагдана.</p>
9.2 Үндсэн	Ажлын явц, сайн дурын ажилтны гүйцэтгэл, нөхцөл байдлыг тогтмол хянана.	<p>9.2а Сайн дурынхан, болон түншүүд төслийн ерөнхий төлөвлөгөөний нэг хэсэг болгон ажлын эхэнд сайн дурын ажилтны ажлын байрны тодорхойлолт, зорилго, ажлын төлөвлөгөөг хянаж, гарын үсэг зурна.</p> <p>9.2б Байгууллагууд сайн дурынхантай тэдний гүйцэтгэл, ажлын тодорхойлсон аливаа үр дүн болон хяналтын шалгалтын дүгнэлтийг хуваалцана.</p> <p>9.2в Сайн дурынхны гэрээний нөхцөлийг тогтмол харьцуулж, хянана.</p>
9.3	Гомдол, санал хүсэлтийн бодлого, журмыг сайн дурын ажилтантай хуваалцаж, ойлгуулна.	<p>9.3а Сайн дурынханд гомдол, санал хүсэлтийн бодлого, журмын талаар ойлголт өгнө.</p> <p>9.3б Байгууллагууд сайн дурынхнаас ирсэн гомдлыг тууштай, ил тод, тэгш байдлаар зохицуулна.</p>
9.4	Сайн дурынхны болон нийгмийн нөлөөлөлд өртсөн сайн дурынхны эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах үйл явц байгаа эсэхийг баталгаажуулна.	<p>9.4а Байгууллагууд сайн дурынхан, түншүүдэд яаралтай тусламжийн үед холбоо барих утасны дугаар, хаягийг өгнө. Яаралтай тусламжийн дуудлагад аюулгүй байдлын төлөвлөгөө, ослын мэдээлэх журмыг ашиглан тууштай хариу өгнө.</p> <p>9.4б Сайн дурынхан осол зөрчлийн стандарт тайланг ашиглан аюулгүй байдал, осол зөрчлийн талаар байгууллагад мэдээлнэ.</p> <p>9.4в Байгууллагууд хамгаалалт, осол зөрчлийн удирдлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын талаарх протоколыг тогтмол хянана.</p> <p>9.4г Сайн дурынхан Ёс зүйн дүрэм, аюулгүй байдлын удирдамжийг дагаж мөрдөнө.</p>
9.5 Үндсэн	Бүх сайн дурынханд мэргэжлийн болон хувийн дэмжлэг үзүүлнэ.	<p>9.5а Байгууллагууд сайн дурынхны хэрэгцээнд нийцүүлэн мэргэжлийн болон хувийн дэмжлэг үзүүлнэ.</p> <p>9.5б Олон улсын болон үндэсний сайн дурынханд тэгш эрх олгоно.</p> <p>9.5в Бүх сайн дурынхан итгэмжлэгдсэн гишүүн эсвэл ажилтнуудтай тулгамдсан асуудлынхаа талаар ярилцаж, дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө гаргах боломжтой.</p>

		<p>9.5г Байгууллагууд Халамжийн үүргийн бодлого, журмыг дагаж мөрдөн, ажлын байран дахь сэтгэцийн эрүүл мэндийн сайн туршлагыг үлгэрлэн үзүүлнэ.</p> <p>9.5д Ажилтнууд сайн дурынхны оруулсан хувь нэмрийг үнэлж, үргэлжлүүлэн суралцах, сайжруулахад дэмжлэг үзүүлэх талаар тогтмол санал бодлоо илэрхийлнэ.</p>
9.6	Сайн дурынхныг ажлаа дуусгавар болгоход дэмжлэг үзүүлнэ.	<p>9.6а Байгууллагаас гарах журам, дагалдах баримт бичигт сайн дурын ажилтан, түнш бүрийн үүрэг хариуцлага, нөөц боллоцоо зэргийг тусгасан байна.</p> <p>9.6б Төслийн төгсгөлд сайн дурынханд зохих мэдээлэл өгч, үүрэг хариуцлагаа дуусгах тухай мэдэгдэл өгнө.</p> <p>9.6в Байгууллага нь сайн дурын ажилтан, байгууллагуудын суралцаж, хөгжсөн байдлыг тодорхойлохын тулд ажлаас гарахын өмнөх ярилцлага авна.</p>

## ЧИГЛЭЛ 10: МЭДЭЭЛЭЛ АВАХ & ТАЛАРХАЛ & БАЙНГЫН ОРОЛЦОО

**Тайлбар:** Байгууллага, сайн дурынхан ажлын туршлагаас суралцана; сайн дурынхныг оруулсан хувь нэмрийг нь үнэлж, хөгжлийн үйлсэд үргэлжлүүлэн оролцоход дэмжлэг үзүүлнэ.

	Гол арга хэмжээ	Үзүүлэлтүүд
10.1 Үндсэн	Сайн дурынхны ажлын үр нөлөөг тусгаж, дүн шинжилгээ хийхэд дэмжлэг үзүүлнэ.	<p>10.1а Байгууллага нь сайн дурынхан, орон нутгийн гишүүд, холбогдох ажилтнуудад ажлын байрны талаар эргэцүүлэн бодож, түүний үр нөлөөг дүгнэхэд цаг хугацаа, хэрэгслээр хангана.</p> <p>10.1б Сайн дурынхан, байгууллагууд тодорхой ажлын байр нь хувь хүний хөгжил, хөгжлийн төслүүдэд хэрхэн нөлөөлдөг тухай бүртгэлтэй байна.</p> <p>10.1в Сайн дурынхан өөрсдийн туршлагыг мэргэжлийн болон нийгмийн орчинд хэрхэн сайн танилцуулж, хэлэлцэх талаар зааварчилгаа авна.</p>
10.2 Үндсэн	Сайн дурынханд зориулсан үйл ажиллагааны болон хувийн мэдээллийг цогц, үр дүнтэй зохион байгуулна.	<p>10.2а Байгууллагын мэдээлэл түгээгч нар үйл ажиллагааны болон хувийн мэдээллийг аль алинд нь тохирсон форматыг дагаж мөрдөхөд суралцсан байна.</p> <p>10.2б Сайн дурынханд мэдээлэл хийх талаар мэдээлэх бөгөөд сайн дурынхан мэдээлэл авахыг хүссэн үед өгнө.</p> <p>10.2в Мэдээллийн явцад сайн дурынхны тавьсан асуудлыг байгууллага хэрхэн шийдвэрлэх талаар сайн дурынханд мэдээлнэ.</p> <p>10.2г Сайн дурынханд санал гомдлыг судлах, хариу өгөх сувгуудын талаар мэдээлэл өгнө.</p>
10.3	Сайн дурынхны оруулсан хувь нэмрийг албан ба албан бус	<p>10.3а Байгууллагууд ажлын төгсгөлд ашиглах ил тод, хүлээн зөвшөөрөх үйл явц, тохиролцсон хүлээн зөвшөөрөх хэрэгслүүдтэй</p> <p>10.3б Байгууллага сайн дурын ажилтны хувийн хөгжил,</p>

	байдлаар хүлээн зөвшөөрч, талархана.	гүйцэтгэлийн амжилтыг албан ёсоор хүлээн зөвшөөрч баталгаажуулахын тулд хангалттай бүртгэл хөтөлнө, жишээлбэл, ажил олгогчийн тодорхойлолт. 10.3в Байгууллага ажлын амжилт гаргасан сайн дурынханд талархал илэрхийлнэ.
10.4	Гэр бүлээсээ алслагдсан, урт хугацааны ажлаас буцаж ирсэн сайн дурынханд албан болон албан бус нүүлгэн шилжүүлэлтийн дэмжлэг үзүүлнэ.	10.4а Байгууллага одоогийн болон хуучин сайн дурынхнаас тэдний хамтрагч нарыг дэмжих туслалцаа үзүүлнэ. 10.4б Байгууллага сайн дурын ажилтныг нийгэмд эргэн орох, боловсрол, сургалтад хамрагдах, ажилд орох, тэтгэвэрт гарахад туслах зааварчилгаагаар хангана.
10.5	Сайн дурынхны тасралтгүй суралцах, хөгжлийн өргөн хүрээтэй хамрах хүрээг дэмжиж, урамшуулна.	10.5а Байгууллага сайн дурынхныг хөгжилд чиглэсэн орон нутаг, бүс нутаг, үндэсний нийгэмлэг, байгууллагуудтай холбогдох боломжийг олгоно. 10.5б Байгууллага сайн дурынханд сайн дурын үйл ажиллагаанд чиглэсэн орон нутгийн байгууллага, тэр дундаа төгсөгчдийн сүлжээтэй холбогдох боломжийг олгоно. 10.5в Байгууллага цахим сайн дурын ажил эсвэл дахин сайн дурын үйл ажиллагаа эрхлэхийг дэмжинэ. 10.5г Байгууллага ажлаасаа гарч буй сайн дурынхантай мэдээлэл, зөвлөгөө авахад харилцаа холбоо тогтоож тусална. 10.5д Байгууллага сайн дурынхан болон гаднын хүмүүсийн хооронд мэдлэг солилцоход тусална.

## ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ

**Зорилт:** Олон нийт, санхүүжүүлэгчид, бусад оролцогч талууд төслийн үр нөлөөг төсөл эхлэхээс өмнө олон нийт, сайн дурынхан, бусад холбогдох талуудын мэдээлэл, ойлголт, оролцоонд суурилан тодорхойлогдсон гэсэн хүлээцтэй байж болно. Төслийн амжилтыг олон нийттэй хамт тодорхойлсон байна.

**Хамрах хүрээ:** Хөгжлийн төлөөх сайн дурын үйл ажиллагааны үр нөлөөг хэмжихэд хамтран ажилладаг байгууллага, түншүүд, сайн дурынхан, олон нийт хамрагдана. Энэ нь цаашдын төслийн боловсруулалт, төлөвлөлтөд тусгагдсан тасралтгүй суралцах, сайжруулах хүрээг бүрдүүлнэ.

### ЧИГЛЭЛ 11: ҮЙЛ ЯВЦ

**Тайлбар:** Хөгжлийн төлөөх сайн дурын үйл ажиллагааны үр нөлөөг хэмжихийн тулд орон нутгийн иргэд, бусад оролцогч талууд болон Тогтвортой хөгжлийн зорилтод хүртээмжтэй, оролцоотой, хариу үйлдэл үзүүлэхэд тогтсон төлөвлөлтийн тогтолцоо, механизм ашиглахыг шаардана.

	<b>Гол арга хэмжээ</b>	<b>Үзүүлэлтүүд</b>
--	------------------------	--------------------

11.1 Үндсэн	Төслийг олон нийтийн тодорхойлсон амжилтын тодорхой үзүүлэлтүүдийг багтаасан төлөвлөлтийн хүрээн дээр үндэслэнэ.	11.1а Байгууллага нь төслийн зорилго нь үйл ажиллагаатай холбоотой эсэх, таамаглалыг тодорхойлж, түршсан байна. 11.1б Байгууллага нь олон нийт, холбогдох оролцогч талуудын хэрэгцээ, хүсэл эрмэлзлийг тусгасан холбогдох үзүүлэлтүүдийг гаргана. 11.1в Байгууллага нь аль болох ТХЗ-ын үзүүлэлтүүдийг ашиглана. 11.1г Байгууллага нь олон нийт, холбогдох талуудтай тохиролцон төслийн орц, гарц, үр дүнгийн талаарх суурь мэдээллийг цуглуулна. 11.1д Байгууллага нь төслөө олон нийт, оролцогч талуудад суурилсан хэрэгцээний үнэлгээ, эрсдэлийн үнэлгээ, байгаль орчны бодлогод үндэслэн боловсруулна.
11.2 Үндсэн	Төслийн олон нийтэд үзүүлэх үх нөлөөний талаар мэдээлэл цуглуулна.	11.2а Байгууллага нь өгөгдөл цуглуулахдаа төслийн зорилго, үр дүнд үндэслэнэ. 11.2б Олон нийт, холбогдох оролцогч талууд өгөгдөл болон мэдээлэл цуглуулах үйл явцад оролцоно. 11.2в Байгууллага нь мэдээлэл цуглуулах хүмүүст-ажилтнууд, сайн дурынхан, зөвлөхүүд эсвэл олон нийтийн гишүүдэд сургалт явуулна.
11.3	Үр нөлөөг хэмжихийн тулд олон нийтийн саналыг ашиглана.	11.3а Олон нийт, холбогдох оролцогч талуудын санал бодлыг чанарын болон оролцооны судалгааны үйл явцыг ашиглан цуглуулна. 11.3б Олон нийтийн гишүүд, холбогдох оролцогч талууд үр нөлөөний судалгаанаас санал авч, олж авсан өгөгдөл, мэдээлэл, дүгнэлтийг баталгаажуулна.
11.4	Сайн дурынхны оруулсан үнэ цэнэ тодорхой байгаа эсэхийг шалгана.	11.4а Байгууллага нь боловсруулалт, хэрэгжилт, хэмжилтийн явцад сайн дурынхны Тогтвортой хөгжлийн зорилтуудад оруулсан тодорхой үнэ цэнийг тодорхойлно. 11.4б Байгууллага нь сайн дурынхны оруулсан тодорхой хувь нэмрийг хөндлөнгийн оролцоо бүхий олон төслийн төлөвлөлт, хэрэгжилтийн хүрээнд ангилсан байхыг баталгаажуулна.
11.5	Үнэлгээний үйл явц, хэрэгслийг орон нутгийн нөхцөлд тохируулан ашиглахад хялбар байдлаар тохируулна.	11.5а Байгууллагын үнэлэх үйл явц, хэрэгсэл нь энгийн бөгөөд олон нийтийн гишүүд, холбогдох оролцогч талууд болон сайн дурынханд ойлгомжтой байна. 11.5б Хэмжилтийн хэрэгслийг орон нутгийн хэл уруу орчуулна. 11.5в Байгууллага нь эмзэг бүлгийн нийгэмд тохирох хэрэгслийг ашиглана (жишээ нь, бичиг үсэг тайлагдаагүй олон нийтэд зориулсан үзүүлэн таниулах хэрэгсэл, янз бүрийн чадварын түвшинд тохирсон хэрэгсэл). 11.5г Байгууллагын үр нөлөөг хэмжих үйл явц "хор хөнөөл учруулахгүй" гэсэн хандлагыг баримтална. 11.5д Байгууллага нь хувийн болон мэдээллийн нүүцлал, аюулгүй байдлыг хангана.

**ЧИГЛЭЛ 12: ҮР ДҮН**

**Тайлбар:** Хөгжлийн төлөөх сайн дурын үйл ажиллагаа нь уг төслийн нөлөөгөөр олон нийт, сайн дурын ажилтан, байгууллагуудад гарсан өөрчлөлт, мөн төсөлд сайн дурын үйл ажиллагааны үүрэг оролцоог тодорхойлно.

	<b>Гол арга хэмжээ</b>	<b>Үзүүлэлтүүд</b>
12.1 Үндсэн	Тодорхойлсон үр дүнд үндэслэн төслийн явц, үр нөлөөг цаг хугацааны явцад хэмжинэ.	12.1a Байгууллага, түншүүдийн үр нөлөөтэй төслүүдийг хэрэгжүүлэх чадавхийг төслийн гарц бүрээр үнэлнэ. 12.1б Байгууллага нь хүчин чадал, чадавхийн хөгжлийг үр нөлөөний үнэлгээтэй уялдуулан тогтмол хэмжинэ. 12.1в Сайн дурынхан чадавх болон тавьсан зорилтуудыг хэрхэн дүгнэх ойлголттой байна. 12.1г Байгууллага нь төслийн зорилго болгон үр нөлөөнд гарч буй ахицыг нэмэгдүүлэхийн тулд хяналт тавина.
12.2	Олон нийтийн эмзэг, гадуурхагдсан гишүүдэд үзүүлэх нөлөөллийг ангилна.	12.2a Сайн дурынхан, байгууллагууд төслийн боловсруулалтад тодорхойлсон хүртээмжтэй байдлыг харуулахын тулд хүн ам зүйн үр нөлөөг тайлагнана. 12.2б Байгууллага нь төслийн хүртээмж, үр нөлөөг хангалттай төлөөлдөггүй олон нийтийн гишүүдийн хүн ам зүйн байдлыг онцлон тэмдэглэнэ.
12.3	Төслийн сайн дурынханд үзүүлэх үр нөлөөг гаргана.	12.3a Байгууллага нь сайн дурын үйл ажиллагааг хувь сайн дурынханд үзүүлэх үр нөлөөг хянана.
12.4 Үндсэн	Үр нөлөөг үнэлэхэд олон нийтийн өөрчлөлтийн ойлголт нөлөөлнө.	12.4a Төслийн үр дүнгийн талаарх олон нийтийн ойлголтыг авахын тулд тэдний оролцоотой семинар зохион байгуулна. 12.4б Олон нийт урьдчилан тооцоолоогүй үр дүнгийн талаар мэдээлэл өгөх боломжтой (ээрэг ба сөрөг) 12.4в Олон нийт үр нөлөөх хэмжих үйл явцын нэг хэсэг гэдгээ мэдэрнэ.

**ЧИГЛЭЛ 13: ТАЙЛАГНАХ**

**Тайлбар:** Үр нөлөө бүхий сайн дурын үйл ажиллагаа нь Тогтвортой хөгжлийн зорилтуудтай холбоотой үр нөлөөний үр дүнг холбогдох бүх талуудад тайлагнахыг шаардана.

	<b>Гол арга хэмжээ</b>	<b>Үзүүлэлтүүд</b>
13.1 Үндсэн	Тогтмол хугацаанд тайлагнаж, эргэх холбоотой байна.	13.1a Түншүүд өөрийн болон өөр орон нутаг, бүс нутаг, улс орнуудад төсөл хөтөлбөр хэрхэн хэрэгжиж байгаа талаар тайлан хүлээн авна. 13.1б Байгууллагууд олон нийт, бусад оролцогч талуудад холбогдох хэл, хэлбэрээр тогтмол тайлагнана.
13.2	Бүх тайланд сайн дурын ажилтны	13.2a Байгууллагуудын тайлан Тогтвортой хөгжлийн зорилтуудад үзүүлэх нөлөөтэй уялдаж, сайн дурын үйл



	<p>оруулсан хувь нэмрийг Тогтвортой хөгжлийн зорилтуудтай үялдуулж байгааг баталгаажуулна.</p>	<p>ажиллагааны үүргийг онцолно.</p> <p>13.2б Байгууллагууд Тогтвортой хөгжлийн зорилтуудад сайн дурынхан, сайн дурын үйл ажиллагааны оруулсан хувь нэмрийг баталгаажуулахын тулд үндэсний засгийн газарт тайлагнана.</p> <p>13.2в Байгууллагууд засгийн газар, бусад оролцогч талуудад тайлагнахдаа “хор хөнөөл учруулахгүй” гэсэн хандлагыг баримтлаж, олон нийт, оролцогч талууд болон ашиг хүртэгчдийн эрхийг хүндэтгэнэ.</p>
13.3	<p>Хөгжлийн төлөөх сайн дурын үйл ажиллагааны үр нөлөөг харуулсан өгөгдөл, бусад нотолгоог хуваалцаж, салбар дотроо хамтран ажиллана.</p>	<p>13.3а Байгууллагууд Тогтвортой хөгжлийн зорилтуудад үзүүлэх үр нөлөөг хэмжиж, үйл ажиллагааг сайжруулахын тулд үр дүн, тайлан болон бусад баримт бичгийг илүү өргөн хүрээний салбартай хуваалцана.</p>

## Уриалга

Сайн дурын үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд болон хөгжлийн төлөө үйл ажиллагаа эрхэлдэг бүх оролцогч талуудад,

НҮБ, Засгийн газрууд болон сайн дурынхны оролцоотой бүх байгууллагууд Үндэсний хөгжлийн хөтөлбөр 2030 он хүртэлх хөгжлийн хөтөлбөрт сайн дурынхны оруулах хувь нэмрийг оновчтой болгох тодорхой бүтцийн хэрэгцээг бага багаар хэрэгжүүлж байна.

Сайн дурын үйл ажиллагаанд чиглүүлэгч зарчмуудын багц байх шаардлагатай нь маргаангүй зүйл. Сайн дурынхны оролцоотой байгууллага (СДОБ)-ууд үйл ажиллагаа явуулж буй улс орон/олон нийтийн төрөл бүрийн нөхцөл байдалд тохируулж, аажмаар өөрчилж болох Үндсэн зарчмуудын талаарх нийтлэг ойлголт дутмаг байна.

Үүнийг шийдвэрлэхийн тулд Форумгаар ахлуулсан багц стандартыг боловсруулах томоохон алхам хийсэн. Кени улсын сайн дурынхны оролцоотой байгууллагуудын нийгэмлэг дэлхийн стандартыг боловсруулахад идэвхтэй оролцох онцгой завшаан тохиосон.

Кени улсын СДОБ Нийгэмлэг Дэлхийн стандартад тусгагдсан гол арга хэмжээ нь сайн дурынхныг оролцуулж буй байгууллагуудад суралцах, сайжруулах сайн хэрэгсэл бөгөөд ажиллаж буй нийгэмдээ эерэг нөлөө үзүүлэхийн тулд өөрсдийн хүчин чармайлтад сайн байр суурь эзэлдэг гэж үздэг.

Миний маш шударга бодлоор, хөгжлийн төлөө сайн дурын үйл ажиллагаа явуулах бидний бүх хүлээлт болон манай нийгмийн нэн хэрэгцээг хангах илүү сайн удирдамж боловсруулах нь хэцүү ажил.

Сайн дурын үйл ажиллагааны салбарт хэсэг хугацаанд тууштай ажиллаж, эрчимтэй дагаж, тулгарч буй бэрхшээл, боломжуудыг ажиглаж - ялангуяа дэлхийн өмнөд хэсэгт байгаа бидний хувьд - би дэлхийн өнцөг булан бүрт байгаа бүх СДОБ-ууд энэхүү стандартыг хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлж, Форумын зорилгод хувь нэмрээ оруулахыг хүлцэнгүйгээр санал болгож байна.

Баярлалаа.

### **Фред Садиа**

Нарийн бичгийн дарга, үндэсний зохицуулагч

Сайн дурынхны оролцоотой байгууллагуудын нийгэмлэг – Кени

## Тайлбар толь

**Амьтны сайн сайхан:** Амьтны төлөв байдал, тухайн амьтан амьдарч буй нөхцөл байдлыг хэрхэн даван туулж байна. Амьтны сайн сайхныг хамгаалах нь түүний бие махбодын болон оюун санааны хэрэгцээг хангана гэсэн үг юм.

**Биологийн төрөл зүйл:** Бүх эх үүсвэрийн амьд организмын харилцан адилгүй байдал, тухайлбал хуурай газрын, далайн болон бусад усны экосистем, тэдгээрийн бүрэлдэхүүн хэсэг болох экологийн цогцолборууд; үүнд төрөл зүйлийн доторх, түүний хоорондын болон экосистемийн төрөл зүйл орно.

**Нүүрстөрөгчийн ул мөр:** Хүн, байгууллага, эдийн засгийн үйл ажиллагаа эсвэл бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн ялгаруулж буй нүүрстөрөгчийн давхар ислээр (CO<sup>2</sup>) илэрхийлсэн хүлэмжийн хийн хэмжээ (GHG).

**Уур амьсгалын өөрчлөлтийн дасан зохицол:** Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг үл харгалзан нийгэмд хөгжихөд туслах аливаа арга хэмжээ.

**Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах:** Хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах эсвэл шингээгчийг сайжруулах хүний оролцоо

**Олон нийт:** Сайн дурын ажилтныг ажиллаж байх хугацаанд хамт ажиллаж байгаа эсвэл тэдний төлөө ажиллаж байгаа хүмүүс, жишээлбэл, тосгон, гэх мэт олон нийт, эсвэл ажил нь нийгэмд ашиг тусаа өгөх хүмүүс, жишээлбэл сүлжээ эсвэл нөлөөллийн байгууллага.

**Хандивлагч:** Хөгжлийн төлөө сайн дурын үйл ажиллагааг санхүүжүүлдэг эсвэл эх үүсвэрээр хангадаг байгууллага. Хандивлагчдад төрийн байгууллага, корпорац, траст, сангууд багтаж болно.

**Экосистемийн хандлага:** Хүн ба нийгмийг бүхэлд нь амьд ертөнцийн нэгэн адил чухалчилдаг хандлага. Хүн бол байгалийн нэг хэсэг бөгөөд түүнгүйгээр нийгэм хөгжихгүй. Газар, ус, амьжиргааны эх үүсвэрийг тогтвортой ашиглах зорилготой.

**Жендерт суурилсан хүчирхийлэл:** Хүйсээр нь тухайн хүнд чиглэсэн бие махбодь, эдийн засаг, сэтгэл зүйн шинж чанартай хор хөнөөлтэй үйлдэл. Жендерт суурилсан хүчирхийлэл нь хүйсийн тэгш бус байдал, эрх мэдлээ үрвүүлэн ашиглах, хор хөнөөлтэй хэм хэмжээнээс үүдэлтэй бөгөөд хувь хүмүүсийг нийгэмд оролцох бүрэн, тэгш эрхийг хаадаг.

**Нэгдмэл хандлага (газар зохион байгуулалтад):** Доройтсон экосистемийг нөхөн сэргээх, үйл ажиллагааг сэргээх аргачлал, бэлчээрийн мал аж ахуйн эзэлсэн бэлчээрийн болон халуун бүсийн тал нутгийн экосистемд зориулан тусгайлан боловсруулсан.

**Байгальд суурилсан шийдэл:** Хүний ая тухтай байдал, биологийн төрөл зүйлийн үр өгөөжийг нэгэн зэрэг хангах, нийгмийн сорилт бэрхшээлийг үр дүнтэй, дасан зохицох замаар шийдвэрлэх байгалийн болон өөрчлөгдсөн экосистемийг хамгаалах, тогтвортой удирдах, сэргээх үйл ажиллагаа.

**Байгалийн нөөц баялаг:** Байгалийн нөөц баялаг бол дэлхий дээрх хүмүүсийн олборлодог зүйлс юм. Ус, хөрс, ашигт малтмал, амьд организмээс авсан бүх зүйлс. Эдгээрийг ихэвчлэн нөхөн сэргээгдэх ба нөхөн сэргээгдэхгүй нөөц гэж ангилдаг.

**Байгууллага:** Хөгжлийн төлөө сайн дурын үйлсийг дэмжих чиглэлээр сайн дурын үйл ажиллагаанд оролцдог байгууллагууд.

**Асрамжийн газар:** Хүүхдүүд гэр бүлтэйгээ хамт амьдрахын оронд богино эсвэл урт хугацааны аль нь ч байж болох асрамжийн газар, хүүхдийн байгууллага бүхий бүх газрууд.

**Түнш:** Түншүүд Хөгжлийн төлөө сайн дурын үйл ажиллагаанд сайн дурын үйлсийг хэрэгжүүлэх үүрэгтэй шууд холбоотой байгууллагуудыг хэлнэ. Үүнд заримдаа илгээгч, хүлээн авагч, уригч байгууллага гэж нэрлэгдэх сайн дурынхны оролцоотой байгууллагууд орно.

**Төсөл ба хөтөлбөр:** Дэлхийн стандарт нь сайн дурынхныг хамарсан, тухайн байгууллага нийгэмд шууд эсвэл олон нийтийн нэрийн өмнөөс хэрэгжүүлж байгаа аливаа үйл ажиллагаанд "Төсөл" гэдэг үгийг ерөнхийд нь ашигладаг. Зарим байгууллагын хувьд 'Хөтөлбөр' нь нийгмийн хүрээнд хэрэгжиж буй хэд хэдэн төслөөр дамжуулан хэрэгжүүлдэг дээд түвшний ажил юм. Дэлхийн стандартад "Төсөл"-г ерөнхий нэр томъёо болгон ашиглах нь байгууллагуудад дэлхийн стандартыг эдгээр хоёр түвшинд хэрэглэхэд саад болохгүй.

**Уян хатан чанар:** Үндсэн үүрэг, өвөрмөц байдал, бүтэц болон дасан зохицох, суралцах, өөрчлөгдөх чадварыг хадгалах арга замаар хариу үйлдэл үзүүлэх эсвэл өөрчлөн зохион байгуулах нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчны тогтолцооны аюултай үйл явдал, чиг хандлага, эмх замбараагүй байдлыг даван туулах чадвар.

**Бэлгийн хүчирхийлэл:** Хүчээр эсвэл тэгш бус эсвэл албадлагын нөхцөлд бэлгийн шинж чанартай бодит буюу заналхийлсэн бие махбодын халдлага.

**Бэлгийн мөлжлөг:** Бэлгийн зорилгоор сул дорой байдал, эрх мэдлийн ялгаа, итгэлцлийн байр суурийг урвуулан ашиглан, гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй, бусдын бэлгийн мөлжлөгөөс мөнгө, нийгэм, улс төрийн ашиг олох аливаа бодит буюу хүчирхийллийн оролдлого.

**Бэлгийн дарамт:** Хүсээгүй бэлгийн хавьталд орох (хүрэхгүйгээр). Үүнд бэлгийн дур хүслийг хангахыг хүссэн эсвэл дайсагнасан эсвэл доромжилсон орчин үүсгэж болзошгүй бэлгийн шинж чанартай үг хэллэг эсвэл бие махбодын бусад зан үйлийг багтана.

**Сайн дурын ажилтан:** Аливаа байгууллагатай ямар нэгэн байдлаар тохиролцон хүмүүст туслахын тулд цаг заваа зориулдаг хүнийг хэлнэ. Энэ нь урт болон богино хугацааны, олон улсын болон үндэсний хэмжээнд ажиллаж байгаа, зардлын мөнгө авдаг эсэхээс үл хамааран ямар ч насны, ямар ч түвшний туршлагатай сайн дурын ажилтнуудыг хэлнэ.

Энд албан ёсны зохион байгуулалтгүйгээр, олон нийтэд түшиглэсэн сайн дурын ажилтнууд эсвэл идэвхтэн тэмцэгч иргэдийг хэлэхгүй болно.

**Хамгаалах:** Байгууллагын ажилчид, сайн дурын ажилтнууд, хамтран ажиллагсад, үйл ажиллагаа, төслүүд нь хүүхэд болон бусад эмзэг бүлгийн хүмүүст хор хөнөөл учруулахгүй байх үүрэг хариуцлага; тэднийг ялгаварлан гадуурхах, үл тоомсорлох, мөлжих, хор хөнөөл, хүчирхийлэлд өртөх эрсдэлд оруулахгүй байх, мөн тэдний ажиллаж буй орон нутгийн хүүхэд, эмзэг бүлгийн хүмүүсийн талаар байгууллагын зүгээс санаа зовж буй аливаа асуудлыг холбогдох байгууллагад мэдээлэх үүрэгтэй. Мөн байгууллагын үйл ажиллагааны үр нөлөөнд өртсөн ажилчид, сайн дурын ажилтнууд, олон нийтийг хамгаалах үүрэгтэй.

***Нэмж дурьдахад, Дэлхийн стандарт нь дор дурьдсан дараах зарчмууд дээр үндэслэсэн болно:***

**Хор хөнөөл учруулахгүй:** Сайн дурын ажилтан дайчлах, олон нийтэд үйлчлэх эсвэл байгаль орчинд тустай үйл хийх үед санамсаргүй байдлаар үүсгэж болзошгүй аливаа сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх ёстой гэсэн зарчим.

**Эрхэд суурилсан хандлага:** хөгжилд хүрэх тухай ойлголт, сайн дурын ажлын тухай ярьж байгаа тохиолдолд сайн дурын үйл ажиллагаа нь "бүяны үйлс"-ээс давж, хүний эрхийн стандартад тулгуурлан, хүмүүст өөрсдийн эрх ашгийг мэдэх, шаардах боломжийг олгоход анхаардаг. Энэ нь хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах төсөл боловсруулж, хэрэгжүүлэх гэсэн үг. Энэ хандлага нь тэгш бус байдал, ялгаварлан гадуурхах үйл ажиллагаа, эрх мэдлийн шударга бус хуваарилалт зэрэг хөгжлийн асуудлын үндсэн шалтгаануудын тухай юм. Сайн дурын үйл ажиллагаа нь эдгээр суурь шалтгаануудыг дэвэргэхгүй байх, оруулж буй хувь нэмэр тогтвортой байхын тулд хүний эрхийг хангахад тулгуурлах ёстой.

**Хариуцлагатай, үр нөлөөтэй сайн дурын үйл ажиллагаа:** Эдгээр нэр томъёог Дэлхийн стандартад тодорхойлсон бөгөөд Дэлхийн стандартыг хангасан байгууллагууд хариуцлагатай, үр нөлөөтэй сайн дурын үйл ажиллагаа явуулж байна гэж итгэлтэйгээр хэлж чадахаар бүтээгдсэн.

## ХАВСРАЛТ: Хувь нэмэр оруулсан байгууллагууд

Форумын Удирдах зөвлөлөөс Дэлхийн сайн дурын стандартыг боловсруулахад ажилтнууд нь цаг зав, мэдлэгээ харамгүй зориулж гаргасан дараах байгууллагуудад талархал илэрхийлж байна.

### Форумын стандартын Ажлын хэсэг (2017 оноос өнөөг хүртэл)

Форумын стандартын Ажлын хэсэг нь Дэлхийн стандартыг боловсруулах ажлыг удирдан чиглүүлэх үүрэгтэй Форумын гишүүн байгууллагуудаас бүрддэг.

Байгууллага	Үүрэг роль	Улс
Комхлам	Хамтарсан дарга	Ирланд
Гадаад дахь сайн дурын ажилтны үйлчилгээ (VSA)	Хамтарсан дарга	Шинэ Зеланд
Хилийн чанад дахь сайн дурын ажилтны үйлчилгээ (VSO)	Зохицуулагч	Их Британи
Австралийн Улаан загалмайн нийгэмлэг (ARC)	Гишүүн	Австрали
Австралийн олон улсын сайн дурынхан(AVI)	Гишүүн	Австрали
Олон улсын хамтын ажиллагааны төв (CECI)	Гишүүн	Канад
Кусо Интернэйшнл	Гишүүн	Канад
Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)	Гишүүн	Герман
Христийн байгууллагуудын олон улсын сайн дурын алба (FOCSIV)	Гишүүн	Итали
Францын сайн дурынхан	Гишүүн	Франц
Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (JICA)	Гишүүн	Япон
Балбын найрамдлын нийгэмлэг	Гишүүн	Балба
Роли Интернэйшнл	Гишүүн	Их Британи
Юнайт	Гишүүн	Швейцар
НҮБ-ын Сайн дурын ажилтнууд (UNV)	Гишүүн	Герман
Канадын Дэлхийн их сургуулийн алба (WUSC)	Гишүүн	Канад

### Тэргүүлэх стандартын лавлагааны групп (2018 – 2019)

Тэргүүлэх стандартын лавлагааны групп нь Дэлхийн стандартыг боловсруулахад дэлхийн хэмжээнд зөвлөгөө өгөх, туршлагаар хангах үүрэгтэй Форумын бус байгууллагуудаас бүрддэг.

Байгууллага	Үүрэг роль	Улс
АЛТО Глобал зөвлөх үйлчилгээ	Гишүүн	Австрали
Бэтэр Кэйр сүлжээ	Гишүүн	Их Британи
Камбожийн сайн дурын сүлжээ (VolCam)	Гишүүн	Камбож
ЭКПАТ Интернэйшнл	Гишүүн	Тайланд
Канадын Хил хязгааргүй инженерүүд	Гишүүн	Канад
Европын сайн дурын төв (CEV)	Гишүүн	Бельги
Гамби сайн дурынхан	Гишүүн	Гамби
Хүмүүний амьдрах орчин	Гишүүн	Филиппин
Хүүхдүүдэд итгэл найдвар ба гэр орон	Гишүүн	Их Британи

Хүмүүнлэгийн академи	Гишүүн	Их Британи
Олон улсын Улаан загалмай, Улаан хавирган сар нийгэмлэгүүдийн холбоо (IFRC)	Гишүүн	Швейцар
Жонс Хопкинсын их сургууль	Гишүүн	Америкийн Нэгдсэн Улс
Лумос	Гишүүн	Их Британи
Амлалтын харандаа	Гишүүн	Америкийн Нэгдсэн Улс
Филиппиний сайн дурын эвсэл (PhilCV)	Гишүүн	Филиппин
Гадаадад хэрэгжүүлэх төслүүд	Гишүүн	Их Британи
Завгүй хөгжил	Гишүүн	Их Британи
Рубарү	Гишүүн	Энэтхэг
Африкийг өөрчлөх нэгдэх	Гишүүн	Кени
ЮНИС	Гишүүн	Америкийн Нэгдсэн Улс
Вайн Траст	Гишүүн	Их Британи
Сайн дурынхны оролцоотой байгууллагуудын нийгэмлэг (VIO нийгэмлэг)	Гишүүн	Кени
Дэлхийн мэдээ алдуулагчдын нийгэмлэгүүдийн холбоо	Гишүүн	Их Британи

### Туршилт хийсэн байгууллагууд (2020)

Туршилт хийсэн байгууллагууд нь Өөрийгөө үнэлэх үйл явцаар дамжуулан Дэлхийн стандартыг турших, Дэлхийн стандарт болон холбогдох хэрэгсэл, нөөцийг боловсруулахад туслах санал хүсэлтийг өгөх үүрэгтэй Форум болон Форумын бус байгууллагуудаас бүрдэнэ. Доор дурдсан 30 байгууллагын 18 нь Өөрийгөө үнэлэх үйл явцыг амжилттай гүйцэтгэсэн бол бусад нь өөр хэлбэрээр туршилтыг дэмжсэн.

Байгууллага	Үүрэг роль	Улс
Эрүүл орчны төлөө сайн дурынхны холбоо (AVES)	Туршилтын байгууллага	Того
Адарша Самажик Проготи Сангста (ASPS)	Дэмжигч байгууллага	Бангладеш
Олон улсын боловсон хүчний хамтын ажиллагааны сүлжээ, тусгай алба (AKLHÜ)	Дэмжигч байгууллага	Герман
JSA нэгдэл	Туршилтын байгууллага	Того
Олон улсын судалгаа, хамтын ажиллагааны төв (CECI)	Туршилтын байгууллага	Канад
Малавид анги танхимын төлөө	Дэмжигч байгууллага	Их Британи
Иргэдийн оролцооны үндэсний консорциум (CNPC)	Туршилтын байгууллага	Мадагаскар
Кусо Интернэйшнл	Туршилтын байгууллага	Канад

Олон улсын сайн дурын хүчин чармайлтын холбоо (IAVE)	Дэмжигч байгууллага	байхгүй
Залуучуудын эрхэм зорилго	Түршилтын байгууллага	Того
Мнгаро Мтаани	Түршилтын байгууллага	Кени
Өмгөөллийн үндэсний форум	Түршилтын байгууллага	Балба
Филиппиний сайн дурын эвсэл (PhilCV)	Дэмжигч байгууллага	Филиппин
Роли Интернэйшнл	Дэмжигч байгууллага	Их Британи
Тогтвортой хөгжлийн төлөөх Руанда санаачилга	Түршилтын байгууллага	Руанда
Руандагийн сайн дурынхны сүлжээ	Түршилтын байгууллага	Руанда
Руандагийн энх тайвны төлөөх залуучуудын клубүүд	Түршилтын байгууллага	Руанда
Сингапурын олон улсын сан (SIF)	Түршилтын байгууллага	Сингапур
Эв санааны нэгдлийн хамтын ажиллагаа (SUCCO)	Дэмжигч байгууллага	Канад
Суданы Улаан хавирган сар нийгэмлэг	Дэмжигч байгууллага	Судан
Свям Бане Гопал	Дэмжигч байгууллага	Балба
Тогтвортой хөгжлийн төлөөх сайн дурын байгууллагуудын үндэсний эвсэл (CNOVD)	Түршилтын байгууллага	Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс
Нэгдсэн зам	Дэмжигч байгууллага	Америкийн Нэгдсэн Улс
Сайн дурынхныг хамарсан сүлжээ	Түршилтын байгууллага	Сьерра Леоне
Сайн дурынхныг хамарсан байгууллагын нийгэмлэг	Дэмжигч байгууллага	Кени
VSO Руанда	Түршилтын байгууллага	Руанда
Канадын Дэлхийн их сургуулийн алба (WUSC)	Түршилтын байгууллага	Канад
Ясан Сукарелаван Сисва (YSS)	Түршилтын байгууллага	Малайз
Завод сайн дурын нийгэмлэг	Түршилтын байгууллага	Словени
Зимбабвегийн ажлын кемпийн холбоо	Түршилтын байгууллага	Зимбабве



**Хяналтын ажлын хэсгүүд (2021)**

Хяналтын ажлын хэсгүүд нь Дэлхийн стандартын 2021 оны хувилбарыг хянаж, шинэчлэх ажилд тусгай мэргэжлийн үр чадвараа дайчлах үүрэгтэй Форум болон Форумын бус байгууллагуудаас бүрдэнэ.

Байгууллага	Үүрэг роль	Улс
Үйл ажиллагааны тусламж	Гишүүн	Грек
Кросроад Интернэйшнл	Гишүүн	Канад
Кусо Интернэйшнл	Гишүүн	Канад
Роли Интернэйшнл	Гишүүн	Их Британи
Мозамбик улсын сайн дурын үндэсний зөвлөл	Гишүүн	Мозамбик
Норек	Гишүүн	Норвеги
Канадын Дэлхийн их сургуулийн алба (WUSC)	Гишүүн	Канад
Яасан Сукарелаван Сисва (YSS)	Гишүүн	Малайз
VSO	Гишүүн	Их Британи

**Форумын Удирдах Зөвлөлөөс мөн дараах байгууллага, хүмүүст талархал илэрхийлж байна:**

- Австралийн Олон улсын хөгжлийн зөвлөл (ACFID), Хүмүүнлэгийн Үндсэн стандарт (CHS) холбоо, Комхлам, Хилийн чанад дахь сайн дурынхны үйлчилгээний (VSO) Олон улсын иргэдэд үйлчлэх хөтөлбөр, Хүүхдийн аюулгүй байдлыг хангах нь өөрсдийн стандартыг боловсруулж, удирдах түршлагаасаа хуваалцлаа.
- 2018 онд дэлхийн зөвлөлдөх санал асуулгад 66 орны 488 сайн дурынхныг оролцуулсан. Санал асуулгын хариулт нь Дэлхийн стандартын загвар, хамрах хүрээг бүртүүлэхэд хувь нэмэр оруулсан.
- Камбож, Канад, Фижи, Гвиней, Энэтхэг, Перу, Филиппин, Руанда, Их Британид болсон есөн дэлхийн зөвлөлдөх семинарын нэгэнд оролцсон сайн дурын байгууллагын 144 хүн. Эдгээр семинар нь Дэлхийн стандартын агуулгыг бүртүүлэхэд хувь нэмэр болсон.

## ХАВСРАЛТ: Ном зүй

Дэлхийн стандарт нь үндсэндээ Форумын гишүүн байгууллагууд болон гишүүн бус байгууллагуудын сайн дурын ажилтнууд болон ажилтнуудын зөвлөгөө авсан туршлага дээр үндэслэдэг. Тэд заримдаа мэдээлэл авсан баримт бичиг, эх сурвалжийг иш татаж байсан. Энд дурьдсан хүмүүсийн жагсаалтыг оруулав.

### Гаднын эх сурвалж:

- ACFID: "Хөгжлийн төлөө хариуцлагатай сайн дурын ажил"-н практик тэмдэглэл, 2018 оны 2-р сар.
- Австралийн Олон Улсын Хөгжлийн Зөвлөлийн (ACFID) Ёс зүйн дүрэм, 2019 он
- Комхлагын сайн туршлагын дүрэм, 2019 он
- CHS холбоо: Хүмүүнлэгийн Үндсэн стандарт ба түүнтэй холбоотой өөрийгөө үнэлэх, баталгаажуулах хэрэгслүүд.
- Европын агентлаг хоорондын аюулгүй байдлын форум: Жижиг төрийн бус байгууллагуудын аюулгүй байдлын эрсдэлийн менежмент: <https://www.eisf.eu/wp-content/uploads/2017/06/2157-EISF-June-2017-Security-Risk-Management-a-basic-guide-for-smaller-NGOs.pdf>
- Бүх нийтийн сайн дурын олон улсын төсөл: <https://www.france-volontaires.org/actualites/ivo4all-8-recommendations-to-create-a-fair-inclusive-environment/>
- Хүүхдийн аюулгүй байдлыг хангах нь: Хүүхдийг хамгаалах олон улсын стандартууд
- OECD/DAC-ийн Хөгжлийн үнэлгээний чанарын стандартууд, 2010 он
- Юнайт: Боловсон хүчний хөгжлийн хамтын ажиллагааны чанарын болон оролцооны нөлөөллийн үнэлгээ, 2018 он
- Сайн дурын Канад стандартууд
- Австралийн Сайн дурын үндэсний стандарт
- VSO, 'Олон улсын иргэдэд үйлчлэх чанарын баталгааны гарын авлага', 2018 он

Дараах байгууллагын бодлого/мэдээлэлээс мэдээллийг нэмж авсан: Хүүхдэд зориулсан итгэл найдвар ба гэр орон, WUSC, CUSO, AVI, VSO, UNICEF, People In Aid, Better Care Network зэрэг байгууллагуудын өгсөн.

### Форумын дотоод баримт бичиг:

- Форумын тэргүүлэх стандартын ажлын хэсгийн баримт бичиг 'Хөгжлийн төлөө сайн дурын үйл ажиллагааны тэргүүлэх стандартуудын тохиролцсон хүрээ', 2018 оны 2-р сар
- 2016-2020 оны Форумын стратеги төлөвлөгөө
- Дэлхийн стандарт тойм, 2018 оны 7-р сар
- Форумын гишүүдийн санал асуулгын дүн шинжилгээ, 2019 оны 4-р сар
- Форумын семинаруудын тэмдэглэл ба хураангуй дүн шинжилгээ, 2018/19
- IVCO 2019 хүрээний цаас, Дэлхийн стандартыг боловсруулах
- Форумын зөвлөл болон Форумын стандартын ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл.

## Онцгойлон талархал илэрхийлье

Хувь нэмрээ оруулж буй байгууллагуудын жагсаалт нь Дэлхийн стандартыг боловсруулахын тулд нэгдэн нийлсэн хамтын нийгэмлэгүүдийн оролцоог илэрхийлж буй юм. Энэхүү ажлыг Форумын Удирдах Зөвлөлийн дэмжлэг, нөөцөөр Форумын Стандартын Ажлын хэсэг удирдан явуулсан. Форум нь Стандартын ажлын хэсгийн гишүүд болон түүний хамтарсан дарга нарт талархаж байна: Комхламын Марк Камминг, Гадаад дахь сайн дурын ажилтны үйлчилгээний (VSA) Стивен Гудман. 2020 онд Дэлхийн стандартыг түршиж, түршлага, зөвлөгөөгөө бидэнтэй хуваалцсан 18 байгууллагад баярлалаа.

Их Британийн Гадаад, хамтын нөхөрлөл, хөгжлийн алба болон Канадын дэлхийн асуудал хариуцсан байгууллагад энэ ажлыг хэрэгжүүлэхэд ихээхэн хэмжээний санхүүгийн дэмжлэг үзүүлсэнд талархаж байна.

Энэхүү төсөлд бичих арга техникийн ажилд оролцож, итгэмжлэгдсэн зөвлөхөөр ажиллаж байгаа Жонатан Поттер болон тэргүүлэх тайланг гаргаж, оролцсон байгууллагуудын түршлагаас суралцах, сайжруулахад тусалсан Жанет Кларк нарт бид талархаж байна. Жонатан, Жанет хоёрын хүчин чармайлтгүйгээр Дэлхийн стандарт төдийлөн чансаатай болж чадахгүй байлаа.

Эцэст нь, Форумын Жеймс О'Брайен болон Хилийн чанад дахь сайн дурынхны үйлчилгээний Рахим Хассанали нарт чин сэтгэлийн талархал илэрхийлье. Тэд анхнаасаа дэлхийн стандартын гол цөм нь байсаар ирсэн бөгөөд Дэлхийн стандартыг боловсруулах, түрших, хянах, нэвтрүүлэх ажлыг зохицуулах үүрэгтэй ажилласан.